



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44. Факс: (976-11) 32-90-84  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2023.03.30 № 1/1294

танаий \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН  
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Ц.ЦЭРЭНПУНЦАГ ТАНАА

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.3-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны үйл ажиллагааны болон системчилсэн үнэлгээний тайлан, санхүүгийн салбарын тоймыг хүргүүлж байна.


Хүндэтгэсэн,

ДАРГА

Д.ВАЯРСАЙХАН



1518000698



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**  
FINANCIAL REGULATORY COMMISSION  
OF MONGOLIA



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2022 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**



Улаанбаатар хот  
2023 он

## АГУУЛГА

### НЭГ. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ БОЛОН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1	Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт.....	3
1.2	Байгууллагын үндсэн үйл ажиллагаа.....	4
1.3	Гадаад харилцаа, хамтын ажиллагаа.....	33
1.4	Зах зээлийн судалгаа, хөгжил.....	9
1.5	Дотоод үйл ажиллагаа .....	39

### ХОЁР. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ.....	44
ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	50

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЭДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
СТБЗ	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
АХБ	Азийн хөгжлийн банк
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариушлагатай компани
ҮҮГ	Улсын үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ҮЦК	Үнэт цаасны компани
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗТХ	Зөрчлийн тухай хууль
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УБАШ	Улсын байцаагчийн албан шаардлага
ЗХШҮ	Зохицой харьцааны шалгуур үзүүлэлт
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХЭХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ҮМҮЧЭТХЭАЗ	Үнэт металл, үнэт чулууны эдлэл, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
ҮХХЗБ	Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага
МУЦАЭХ	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо
BХҮҮ	Вишуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
БНЭУ	Бүгд найрамдах энэтхэг улс
БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
ҮХЭХБХСЗ	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал
АНДМУТБ	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг
IPO	Initial public offering /Олон нийтэл хувьцаатын санал болгох/
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
АЗЗА	Авто замын засвар арчлалт
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ГҮТББ	Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага
ТоС	Монголын тогтвортой санхүүгийн холбоо
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
МУТА	Мөнгө угаахтай тэмцэх алба
ЗМС	Зээлийн мэдээллийн сан
ЗХХА	Захиргааны хэм хэмжээний акт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
МХБ	Монголын хөрөнгийн бирж
JICA	Japan International Cooperation Agency /Японы олон улсын хамтын ажлыгээгээс байгуулсан/
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ЭСЯ	Элчин сайдын яам
ОХУ	Оросын Холбооы Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
АНЭУ	Арабын Нэгдсэн Эмират Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ҮХЭХЗ	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023.02.06

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “СЗХ” гэх/-ны 2022 оны үйл ажиллагааны тайланда Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2011 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 55 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн болно.

### НЭГ. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ БОЛОН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн, тавьсан зорилгодоо хүрсэн эсэхийг тодорхойлоход чиглэх бөгөөд үнэлгээ хийхдээ “Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ”-ний хэлбэрийг сонгож, дараах төрлөөр үнэлгээ хийлээ. Үүнд:

1. Байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт
2. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа /процессын/
3. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
4. Зах зээлийн судалгаа, хөгжил
5. Дотоод үйл ажиллагаа

#### 1.1 БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

*Зураг1. Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц зохион байгуулалт*



СЗХ нь 2022 онд 9 газар, 5 хэлтэс, 5 албан дийт 162 албан хаагчтайгаар б салбарын 3716 зохицуулалттай этгээд, 2376 даатгалын төлөөлөгчдөд хяналт шалгалт хийж, бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Мөн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй зохицуулалтын байгууллагуудын нэгдсэн бүртгэл хөтөлж, шаардлагатай мэдээллүүдийг тогтоосон хугацаанд СЗХ-нд ирүүлэх, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохицуулалтын байгууллагуудад хяналт тавих үүрэг бүхий орон нутгийн 63 төлөөлөгчид Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт ажиллаж байна.

## 1.2 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 бүлэг 47 зорилтын хүрээнд 257 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар тайлagnasan байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, төлөвлөсөн түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр 95 хувь буюу “Тодорхой үр дунд хүрсэн” үнэлгээтэй байна.

Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 30 хууль болон 120 орчим дүрэм, журам, заавар, аргачлалыг дагаж мөрдөх эрх зүйн орчинд зохицуулалтыг хийжээ.

Бодлогын баримт бичгийн хүрээнд Дээд газрын 17 тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 93.6 хувийн гүйцэтгэлтэйгээр холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлсэн ба шинээр буюу шинэчлэн найруулсан, өөрчлөлт оруулж баталсан Монгол Улсын хууль 484, Монгол Улсын Их Хурлын тогтоол 78, Засгийн газрын 2 тогтоолыг хүлээн авч, СЗХ-ны үйл ажиллагаанд шууд хамааралтай тогтоол шийдвэрүүдийн биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд СЗХ-оос баталсан тогтоол, тушаал, шийдвэрүүд:

*Хүснэгт 1. СЗХ-ны хуралдаан, СЗХ-ны даргын болон Ажлын албаны даргын шийдвэрүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл:*

№	Тушаал, шийдвэрүүдийн ангилаал	Тоо	Шийдвэрлэлт
1	Хорооны хуралдаан	Хорооны тогтоол	739
2	Хорооны дарга	Тушаал	553
3	Ажлын албаны дарга	Тушаал	414

Хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн асуудлыг зохицуулалтын салбараар авч үзвэл үнэт цаасны зах зээлийн 145, даатгалын зах зээлийн 52, банк бус санхүүгийн байгууллагын 241, хадгаламж зээлийн хоршооны 108, үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын 168, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах 23, бусдаар 2 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

1.2.1 САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАЛГАХ, САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭСЭГ ЗОХИЦУУЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХИЙСЦИЛЖИЛСЭН АРГА ХЭМЖЭССЭН:

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ) 2022 онд нийт 3 удаа хуралдаж, 9 асуудал хэлэлцэн шийдвэрлэж холбогдох чиглэл, зөвлөмжийг өгч ажилласан байна.

Зөвлөлийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооноос 3 асуудал хэлэлцүүлсэн. Үүнд: Монгол Улс дахь виртуал хөрөнгө, түүний зохицуулалт. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлангийн танилцуулга, “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг шинэчлэн батлах тухай асуудлууд багтсан байна.

СЗХ-ноос СТБЗ-ийн хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд оролцсон байна.

НЭГ. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2022 оны I улиралд олон улсад үүсээд буй геополитикийн хурцадмал байдалтай холбоотой хоёр удаа ээлжит бус хуралдаан

зохион байгуулж 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 6 дугаар болон 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр 7 дугаарын зөвлөмжийг гаргасан.

**ХОЁР.** Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн II улирлын ээлжит хуралдаан 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдаж, дараах асуудлыг хэлэлцжээ. Үүнд:

- 2.1. Монгол Улс дахь виртуал хөрөнгө, түүний зохицуулалтын танилцуулга;
- 2.2. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үүдэсний эрсдэлийн үнэлгээний тайлангийн танилцуулга;
- 2.3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Төв банкны арилжааны нэгдсэн системийн танилцуулга.

**ГУРАВ.** Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2022 оны IV улирлын ээлжит хуралдаан 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр хуралдах байсан боловч ажлын журмаар шийдэгдэх болсон. Хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлууд:

- 3.1. Хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны хязгаарлалтыг банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад мөрдүүлэх;
- 3.2. Автомашины зээлд - зээл, үнэлгээний харьцаа (LTV) тогтоох;
- 3.3. “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг шинэчлэн батлах тухай;
- 3.4. Зөвлөлийн 2023 оны хурлын товыг тогтоох тухай.

### **ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлаар Монгол Улсын эдийн засгийн төлөв, гадаад орчинд үүсэж буй эрсдэл, тодорхой бус байдлын талаар хэлэлцээд макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх хүрээнд бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх тодорхой зөвлөмжүүд, тухайлбал олон улсын төлбөр тооцооны тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллахыг зөвлөсөн байна.

Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаасны төлбөр тооцооны горимыг олон улсын жишигт нийцүүлэх ажилд онцгойлон анхаарч бодлогын арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлэн төлбөр тооцооны T+2, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх шийдвэрийг гаргаснаар системийн хэмжээнд энэхүү горимд амжилттай шилжсэн байна.

Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдыг дэмжиж, үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамжийг бууруулах чиглэлээр бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд олон улсад хөрөнгийн зах зээлийн индексийг тодорхойлогч Их Британийн FTSE Russell-с гаргадаг Хөгжикж буй зах зээл (Frontier Market) ангиллын жагсаалтад Монгол Улс ангилал ахих боломж бүрдэж 2022 оны есдүгээр сарын 29-ний өдөр хөгжикж буй зах зээл (Frontier Market) ангилалд албан ёсоор оржээ.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны жилийн эцсийн байдлаар 6.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд нийт 594.8 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн бөгөөд үүнээс 343.4 тэрбум төгрөг буюу 57.7 хувийг хувьцаа, 134.0 тэрбум төгрөг буюу 22.5 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 103.7 тэрбум төгрөг буюу 17.4 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 13.6 тэрбум төгрөг буюу 2.2 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус бүрдүүлжээ.

Харин хувьцааны хөрвөх чадварын үзүүлэлт тайлант хугацаанд 2.4 хувь болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.42 пункттээр буурсан бөгөөд манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны төвлөрөлт хэт өндөр байгаатай холбоотой юм. Тухайлбал, 2022 оны жилийн эцсийн байдлаар ТОП-20 индекст багтах компаниудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 76 хувийг хувьцаа эзэмшигчдийн 0.05 хувь нь эзэмшиж байна.

Үнэт цаасны омчлөх эрхийн бүртгэлийн тогтолцоог шинэчлэн, төвлөрсөн болон тухайлан бүртгэл хоорондын уялдаа холбоог хангах, брокерийн компаниудын чадавхийг сайжруулж, харилцагчдад үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай болгох чиглэлээр мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал даансны зохицуулалтыг олон улсын жишгийн дагуу боловсруулан баталжээ.

Олон улсын хөрөнгийн зах зээлийн интеграцид нэгдэх, гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг дотоодын биржид давхар бүртгэх чиглэлээр Үнэт цаасны давхар бүртгэлийн журамд хөрөнгө оруулагчид дотоодын болон гадаадын биржүүдийн хооронд үнэт цаасыг чөлөөтэй хөрвүүлэн арилжаалах зохицуулалтыг бий болгож, өмчлөх эрхийн бүртгэлийн холимог тогтолцоог бий болгожээ.

Мөн Азийн хөгжикж буй болон хөгжингүй хөрөнгийн зах зээлтэй орнуудад түгээмэл хэрэглэгддэг хадгаламжийн бичгийг хөгжүүлэх чиглэлээр хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих журмыг баталсан байна.

Ингэснээр дотоодын аж ахуйн нэгжүүд гадаад улсад хадгаламжийн бичиг гаргах, гадаадын аж ахуйн нэгжүүд Монгол Улсын хадгаламжийн бичгийг гаргах боломж бүрдсэн байна.

Хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчинг боловсронгүй болгох ажслын хүрээнд:

Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчинд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон тус хуулийг дагалдан өргөн баригдах Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлциүүлэн, 2023 оны Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаа хялбар, шуурхай болж, зохицуулагч болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн хоорондын уялдаа холбоо сайжран олон улсын жишигт нийцэх, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх, үнэт цаас гаргагч, андеррайтерийн компаниудын үүрэг оролцоо ёсөх, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, төвлөрсөн болон тухайлсан бүртгэлтэй холбоотой зохицуулалт боловсронгүй болох зэрэг нөлөө хөрөнгийн зах зээлд бий болохоор байна.

СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд “бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох” гэж заасны дагуу 2022 онд хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын чиглэлээр дараах хэм хэмжээ тогтоосон актыг шинээр болон шинэчлэн боловсруулж баталжээ. Үүнд:

1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам;
2. “Төрийн болон орон нутгийн өмчit нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журам”;
3. “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”;
4. “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулан баталж, мөрдүүлэн ажиллаж байна.

Банкны салбарын реформ:

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталснаар банкны системд нөлөө бүхий банк (системийн банк)-үүд IPO хийх замаар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлтгэй хувьцаат компани болохоор хуульчилсан нь дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжилд томоохон эсрэг өөрчлөлтийг бий болгож байна.

Монгол Улсад нийт 5 системийн банк /Хаан банк, ХХБ, Төрийн банк, Хас банк, Голомт банк/ үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүнээс “Төрийн банк” ХХК нээлттэй хувьцаат компани болох ажлыг эхлүүлж, анхдагч зах зээлд хувьцааны арилжааны захиалга нь 100 хувийг давж, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтыг амжилттай татан төвлөрүүлсэн.

СЗХ-ны 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 634 дүгээр тогтоолоор “Голомт банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэсэн бөгөөд тус банк нь нийт гаргасан хувьцааныхаа 10 хувь буюу 80,402,743 ширхэг хувьцааг 1,285 төгрөгөөр олон нийтэд санал болгож, олон нийтээс 103.3 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн нь нээлттэй ХК болсон банкны системд нөлөө бүхий хоёр дахь банк болсон.

СЗХ-ны 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 689 дүгээр тогтоолоор “ХААН банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэсэн бөгөөд тус банк нь 2023 оны 1 дүгээр улиралд багтаан анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгох ажиллагааг хэрэгжүүлэх хүлээлттэй байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьчалал:

Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийг баталсан байна.

Энэ хүрээнд Засгийн газраас 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар 2022-2023 онд биржээр төрийн мэдлийн 34 хувийн хувьцааг нээлттэй худалдах, олон нийтийн хяналтад шилжүүлэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтыг баталсан бөгөөд уг жагсаалтад “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Үндэсний давхар даатгал” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ болон бусад 20 АЗЗА багтсан байна.

Төрийн өмчит компаниудын хувьчлалын үйл ажиллагааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК эхлүүлэн, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 690 дүгээр тогтоолоор бүртгэсэн нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээний нэмж гаргах хувьцааг олон нийтэд санал болгож 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулсан бөгөөд нийт хөрөнгө оруулагчдаас 57,865,745,500 төгрөгийн үнийн дүн бүхий 7414 захиалга ирсэн нь татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн дүнгээс 4.8 дахин давсан үзүүлэлт болсон байна.

*Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа:*

СЗХ-ноос “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталснаар Монгол Улсад анх удаа үнэт цаас гаргагч компаниудаас арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны бүртгэлийн өндөр шалгуурыг хангахгүйгээр биржийн бус зах зээлд түргэвчилсэн, шуурхай байдлаар компанийн өрийн хэрэгслийг гаргаж, урт хугацааны санхүүжилт татах зохицуулалтын орчин бүрдсэн байна.

МУЦАЭХ нь биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2022 оны жилийн эцэс хүргэлх хугацаанд биржийн бус зах зээлд нийт 61 үнэт цаас гаргагчийн нийт 1.42 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 78 компанийн бондыг бүртгэж, үнэт цаас гаргагчийн зүгээс нийт 940.8 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлжээ.

*Ходоо аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн зах зээл:*

Хөдөө аж ахуйн биржээр 2022 оны байдлаар нийт 1.1 их наяд төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 315.8 тэрбум төгрөгөөр буюу 39.7 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт 5 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна.

*Арилжааны хэлцлийн зардлыг бууруулах, арилжаа хийгдэх шат дамжулагыг багасгах ажлын хүрээнд:*

Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн 4.1 дэх хэсэгт заасан “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулах” арга хэмжээний хүрээнд үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдыг дэмжихтэй холбогдуулан бодлого, зохицуулалтын дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1/2022 оны 2 дугаар улиралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-д сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс, нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувийг хэмжээнээс хамааруулан хязгаар тогтоож, 50-75 хувиар бууруулан 0.25-0.5 хувь болгосон. Мөн жилийн үйлчилгээний хөлсний хэмжээ сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 0.1 хувийг 50 хувиар бууруулж 0.05 хувь болгосон;

2/ 2022 оны 2 дугаар улиралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Бүртгэлийн журам”-д хувьцааг бүртгэх үйлчилгээний хөлс, нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 0.1 хувийг хэмжээнээс хамааруулан 20-40 хувиар бууруулан 0.06-0.08 хувь болгосон. Мөн өрийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлс, үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийн 0.1 хувийг үнийн дүнгээс хамааруулан 0-36 хувиар бууруулан 0.064-0.1 хувь болгосон;

3/ 2022 оны 2 дугаар улиралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Арилжааны журам”-д хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаанд худалдсан тал шимтгэлгүй байх, түүнчлэн худалдан авагчийн хувьд хэлцлүүдийн үүийн нийлбэр дүнгээс хамааруулан шимтгэлийг тооцдог байхаар зохицуулалтыг тусгасан бөгөөд тус журмыг СЗХ-ны 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 335 дугаар тушаалаар батламжилсан;

4/ “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Үнэт цаасыг нийтэд санал болгох, худалдах, хуваарилах ажиллагааны журам”-ын нэгдүгээр хавсралтын 1.1-д Хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хувьд гэснийг: “1.1.1. 0-3,000 ширхэг хэлцэлд - 10.0 сая төгрөг, 1.1.2. 3,001-5,000 ширхэг хэлцэлд - 20.0 сая төгрөг, 1.1.3. 5,001 ширхэг, түүнээс дээш хэлцлийн тухайд нийт үнийн дүнгийн 0.2 хувь байх бөгөөд хамгийн ихдээ 40 сая төгрөг” гэж өөрчлөн найруулах саналыг албан бичгээр хүргүүлсэн;

5/ “ҮЦТХТ” ХХК-д биржийн бус зах зээлд үнэт цаас гаргагчаас хаалттай хүрээнд гаргасан үнэт цаасыг бүртгэх, хадгалах, түүний өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой хураамжийг “ҮЦТХТ” ХХК-ийн холбогдох журамд нарийвчлан тусгасны үндсэн дээр сүүтган авч ажиллахыг үүрэг болгож, албан бичгээр чиглэл хүргүүлсэн байна.

#### Ногоон тогтвортой санхүүжилт:

Төрийн ордонд 2022 оны 3 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ногоон санхүүжилт бус нутгийн чуулган”-аар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагууд болох Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпорациын удирдлагууд “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг баталснаар нээлттэй хувьцаат компаниудыг байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан гаргаж мэдээлдэг болох, дотоодын аж ахуйн нэгжээс ногоон бонд гаргах замаар байгаль орчинд ээлтэй төсөл, хотөлбөр санхүүжүүлэх тогтолцоо бүрдэх чухал ач холбогдолтой алхам болсон байна.

Хөрөнгийн зах зээлийн 30 жилийн ойт тохиолдуулан “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-тай хамтран үнэт цаас гаргахаар сонирхож байгаа аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд урт хугацаат хямд өртөг бүхий

хөрөнгийг олон нийтээс хэрхэн амжилттай татан төвлөрүүлэх, үнэ цэнэ өсгөх, цаашид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг хэрхэн татах, тэдний итгэлийг хүлээсэн сайн засаглал бүхий хариуцлагатай компанийг бий болгох, тогтвортой өсөж хөгжих бодит боломжийг таниулах зорилгоор “IPO Mongolia 2022 Forum - Хүртээмжтэй хөрөнгийн зах зээл” арга хэмжээг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулжээ.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй компаниуд, үнэт цаас гаргагч аж ахуйн нэгжүүд болон бусад бизнесүүдэд зориулсан Байгаль орчин нийгэм, засаглал, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж, гарын авлагыг Санхүүгийн зохицуулах хороо, Олон улсын санхүүгийн корпораци, НҮБ-ын Хөгжлийн хотолбөр болои бусад хамтрагч байгууллагуудын хамт боловсруулан, дээрх форумын үеэр шийтэд танилцуулж, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК болон Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС Холбоо)-ны цахим хуудсанд байршуулсан байна.

Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр хувьцаат компаниудын ногдол ашгийг жижиг хувьцаа эзэмшигч нарт чирэгдэлгүй хурдан шуурхай тараах ажиллагааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкны дансанд байршуулах зохицуулалтыг бий болгосон байна.

Үнэт цаасны бүртгэл зөвшөөрлийн чиглэлээр 2022 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх чиглэлээр нийт 70 асуудлыг СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, мөн 22 компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох, 13 компанийн гүйцэтгэх захирал томилохыг зөвшөөрөх, 8 компанийн мэргэшсэн нягтлан бодогчийг томилохыг зөвшөөрөх, 1 компанийн салбар байгуулахыг зөвшөөрөх, 1 компанийн оноосон нэрийг өөрчлөх болон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай 3 асуудлыг СЗХ-ны даргын тушаалаар шийдвэрлүүлсэн байна.

### **ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ**

Даатгалын салбарыг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалын салбарыг илүү тогтвортой, эдийн засагт үр нөлөө үзүүлдэг, бодит салбар болгон хөгжүүлэх шинэчлэлийн гол үйл ажиллагаа нь салбарын хуулийн шинэчлэлийм.

Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам хамтран 2022 онд салбарын гол хуулиуд болох Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, салбарын оролцогчид болон иргэд, олон нийтээс санал авч, хуулийн төслийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд давхар даатгалын болон амьдралын даатгалын үйл ажиллагааг дэмжих, даатгагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, даатгалын үйл ажиллагааг цахимжуулах, заавал даатгалын нэгдсэн зохицуулалтыг бий болгох зэрэг томоохон өөрчлөлтүүдийг тусгажээ.

Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд даатгалын зуучлалын үйл ажиллагааг төрөлжүүлж, олон улсын жишигийн дагуу мэргэшүүлэх, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг Даатгалын тухай хуульд шилжүүлэх, давхар даатгалын зуучлалын зохицуулалтыг тусгаж шинэчилсэн байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн жолоочийн хариуцлагын даатгалын зарчмыг олон улсын жишигт нийцүүлэх, даатгалын үнэлгээ болон хураамж тооцох аргачлал, итгэлцүүрийг шинэчлэх, жолоочийн даатгалын сангийн зохицуулалтыг сайжруулах, нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг хялбаршуулж, шуурхай болгох чиглэлээр холбогдох өөрчлөлтүүдийг тусгажээ.

Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор даатгалын салбарт тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох үйл ажиллагаа, тэдгээртэй холбоотой дүрэм, журмуудыг хуульд нийцүүлэх чиглэлээр судалж Даатгалын багц дүрмийн холбогдох хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан байна.

Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбооноос баталсан “Даатгалын тулгуур зарчим”-ыг үе шаттайгаар нэвтрүүлэх хүрээнд Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд даатгалын 25 тулгуур зарчмыг тусгах чиглэлээр судалгаа хийсэн ба холбогдох зарчмуудыг хуулиудын шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан.

Эдгээр зарчмуудыг тусгаснаараа даатгалын салбарын хууль, тогтоомжууд олон улсын стандартад нийцэх, цаашид дүрэм журмуудад нарийвчлан оруулж хэрэгжүүлэх боломж бүрдэх бөгөөд салбарын холбогдох дүрэм, журмыг шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэжээ.

Манай улсын даатгалын салбарын эрх зүйн орчинд ногоон даатгал гэх нэр томъёоллыг тодорхойлоогүй ч байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбогдох даатгалын бүтээгдэхүүнүүд борлуулагдаж байна. Тухайлбал, “Практикал” даатгалын унадаг дугуйны иж бүрэн даатгал, “Номин” даатгалын приус автомашины даатгал зэрэг байгальд ээлтэй үйл ажиллагааг дэмжсэн даатгалын бүтээгдэхүүнүүдийг СЗХ-нд бүртгүүлээд байна.

Ногоон даатгалын үйл ажиллагаа, даатгууллагчдад санал болгож буй ногоон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар судалгаа хийж, ногоон даатгалын эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр даатгалын компаниудыг хамруулсан хэлэлцүүлгийг 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулжээ.

Хэлэлцүүлгийн үр дүнд гарсан саналуудыг тусган Даатгалын багц дүрмийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”, хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”, арваанэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-т СЗХ-ны 2022 оны 129 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан салбарын хэмжээнд хэрэгжүүлэх ногоон даатгалын эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

Жолоочийн даатгалын санд даатгагчаас төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 2022 онд даатгагчийн 2021 оны жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлогод тооцсон хураамжийн дүнгийн 1.6 хувиар тооцож, уг хөрөнгийг 2022 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийн дотор Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх талаар тушаалын төслийг боловсруулж Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 451/196 дугаар тушаалаар баталжээ.

Даатгалын бүртгэл зөвшөөрлийн чиглэлээр 2022 онд СЗХ-нд нийт 288 албан бичгээр 905 хүсэлт ирүүлснээс 721 хүсэлтийг шийдвэрлэж, 152 хүсэлтийг буцааж, 32 хүсэлт хянагдаж байна. Тодруулбал, урт хугацааны даатгалын 1, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 7, даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн 368 хүсэлт, даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах 190 хүсэлтийг тус тус СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн ба даатгалын компанийн хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгө, салбар төлөөлөгчийн газар, оноосон нэр, эрх бүхий албан тушаалтан, даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн, актуарч, зуучлагчийн эрх, даатгалын мэргэжлийн оролцогч, хаяг байршлын өөрчлөлт зэрэг 242 хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

#### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР

Санхүүгийн үйлчилгээг эрхлэх хууль эрх зүйн орчныг Олон улсын санхүүгийн зах зээлд өрсөлдөхүйц, эдийн засгийг тэтгэсэн, чанартай, хүртээмжтэй санхүүгийн систем, цаашилбал цахим технологид суурилсан, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалсан, иргэдэд ээлтэй, хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээг бүрдүүлэхэд чиглэсэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж хууль санаачлагчид хүргүүлж улмаар УИХ-д өргөн барьсан байна.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 5 дугаар сарын 10,19-ний өдрүүдийн хуралдаанаар хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж Эдийн

засгийн байнгын хорооны 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 06 дугаар тогтоолоор нэр бүхий УИХ-ын гишүүдийн бүрэлдэхүүнтэй хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллаж байна.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Европын сэргээн босголт хөгжлийн банктай хамтран зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт нийт 120 гаруй салбарын оролцогчид хамрагдажээ.

Мөн Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Хууль зүйн яамнаас боловсруулсан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт СЗХ-ны төлөөлөл ажиллаж, УИХ-ын чуулганаар 2022 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр баталж, 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тусгагдсан байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын хувьд тус газраас 2022 онд бодлого, зохицуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

1. Зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалсан, банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/-ын зээлийн хүү, түүнтэй холбоотой үйлчилгээний шинтгэл, хураамжийн зохицуулалтыг тодорхой болгосон Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам;
2. “Банк бус санхүүгийн байгууллагын эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын журам”-д нэмэлт өөрчлөлт;
3. Банк бус санхүүгийн байгууллагуудаас хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтийг хүлээн авах хугацааг 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд сунгах;
4. Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хүлээн авахгүй байх;
- 5.“Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”;
- 6.“Банк бус санхүүгийн байгууллагаас олгох фингитеек зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа тогтоох тухай” тогтоол;
- 7.“Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, Санхүүгийн тайлангийн маягт, Дансын нэгдсэн жагсаалт, Санхүүгийн тайлангийн тодруулгын төслийг Сангийн яамтай хамтрай батлахаар ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд ББСБ-ууд дэвшилтэт технологид суурилсан зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлж тэр хэмжээгээр харилцагчдын тоо өссөн үзүүлэлттэй байгаа нь цаашид зээлийн бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журамд зээлийн бүтээгдэхүүнээс үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор ББСБ-ууд нь мэргэжлийн ёс зүйтгэй байх, шимтгэл хураамжийг өндөр тогтоохгүй, зээлийн хүүг шимтгэл, төлбөр хэлбэрээр тооцохгүй, зээлийн хүүг ашигласан хугацаагаар тооцох, зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлдэг байх, зээлдэгчээс гэрээнд тусгагдаагүй шимтгэл, хураамж төлөхийг шаардахгүй байх зэрэг зохицуулалтуудыг бий болгожээ.

ББСБ-ууд нь дэвшилтэт технологид суурилсан /финтек/ зээлийн бүтээгдэхүүн гаргах тохиолдолд СЗХ-нд бүртгүүлэх, зээлдэгчийг орийн дарамтад орохоос урьдчилан сэргийлж финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцааг 70 хувиас хэтрүүлэхгүй байх, харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангасан технологийн шийдлийг нэвтрүүлэх зэрэг харилцагчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалтын орчныг бүрдүүлэхэд анхааран ажиллажээ.

Мөн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний шимтгэл, хураамжийг өндөр тогтоосон ББСБ-дад СЗХ-оос бууруулах санал хүргүүлэх, бууруулаагүй тохиолдолд тухайн ББСБ-ын шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авахаар тусгасан нь ББСБ-ын зээлийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг илүү тодорхой болгох, зээлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах, харилцагчийг орийн дарамтанд орохоос урьдчилан сэргийлэх, финтек зээлдэгчдийн мэдээллийн аюулгүй байдал, шууцлал болон харилцагчдын эрх ашгийг хамгаалах чухал ач холбогдолтой болсон байна.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн А-7/08/4 дүгээр хамтарсан тушаалаар харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг жилийн 3 (гурав) хүртэл хувиар тогтоосон байна.

ББСБ-ын салбарын бүртгэл зөвшөөрлийн чиглэлийн 2022 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 17, нэмэлт тусгай зөвшөөрөл хүссэн 35, нэгдэх нийлэх 4, хаалттай өрийн бичиг гаргах 36, нийт 92 асуудлыг хянаж СЗХ-ны хуралдаанаар шийдвэрлүүлжээ. Нийт ирүүлсэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүсэлтийн шийдвэрлэлт 93.6 хувьтай байна.

СЗХ-ны 2019 оны 441 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай 232 ББСБ-аас нэмэгдүүлэх хүсэлт ирүүлсэн 230, хүсэлт ирүүлээгүй 2 байна. Үүнээс: Хорооны даргын тушаалаар хувь нийлүүлсэн

хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн 192, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 24, хүсэлт хянагдаж байгаа 14 ББСБ байна.

Оноосон нэр өөрчлөх 10, салбар нэгж байгуулах 44, салбар нэгж хүчингүй болгох 3, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувь хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах 283, хоёрдогч өглөг гаргах 3, нийт 343 хүсэлтийг СЗХ-ны даргын тушаалаар шийдвэрлүүлсэн бөгөөд зөвшөөрөлтэй холбоотой ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт 97.9 хувьтай, гүйцэтгэх удирдлага өөрчлөх 111, хаяг, байршил өөрчлөх 83, ТҮЗ бүртгэх 45, нэгдсэн бүртгэлд өөрчлөлт оруулах 12, бусад 38, нийт 289 хүсэлтийг цахимаар хүлээн авч, бүртгэл хөтөлсөн нь цахим хүсэлтийн шийдвэрлэлт 99.3 хувийн биелэлттэй байна.

Нийт 513 ББСБ зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж байгаагаас зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг 479 ББСБ-ын 465 буюу 97 хувь нь ЗМС-тай гэрээ байгуулсан байна.

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хадгаламж, зээлийн хоршооны хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн 3 давхаргат хамгаалалтын тогтолцоог бий болгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зохицуулалтын орчинг тодорхой, оновчтой болгох өөрчлөлтүүдийг тусган Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдлийг хангаж хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга, харьцуулсан судалгааны хамт хууль санаачлах эрх бүхий этгээд /УИХ-ын гишүүн/-д хүргүүлсэн байна.

Хадгаламж зээлийн хоршооны салбарын чиглэлээр 2022 онд дараах хэм хэмжээ тогтоосон актыг шинээр болон шинэчлэн боловсруулж баталжээ. Үүнд:

1. СЗХ-ны 2018 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлж, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан;

2. “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулсан бөгөөд 2022 онд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулсан ХЗХ-дын мэдээлэлд үндэслэн зайны аргачлалыг туршиж эхэлсэн;

3. СЗХ-ны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн батлахаар төслийг боловсруулж, 2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр АХБ-ны төслийн зөвлөхүүдэд танилцуулан хэлэлцүүлэг хийсэн;

4. “Хадгаламж, зээлийн хоршооны ажилтны ёс зүйн дүрмийн үлгэрчилсэн загвар”-ын төслийг боловсруулж, удирдлагуудад танилцуулсан байна.

Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон нэр бүхий 2 ХХК-тай “зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа 196 ХЗХ-ны 47.9 хувь буюу 94 ХЗХ шинээр болон шинэчлэн байгуулсан байна.

Тайлант хугацаанд нийт 13 ХЗХ-оос ирүүлсэн хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт, холбогдох баримт бичгийг хянаж, хуульд заасан шаардлагыг хангасан нэр бүхий 7 ХЗХ-нд СЗХ-ны тогтоолоор тусгай зөвшөөрөл олгож, 5 ХЗХ-ны баримт бичиг шаардлага хангаагүй тул тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тухай мэдэгдлийг албан бичгээр хүргүүлжээ.

Нэр бүхий 65 ХЗХ-оос тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлт ирүүлснээс 62 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах асуудлыг СЗХ-ны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн бөгөөд 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хууль, журмын дагуу хүчингүй болгосон. Нэр бүхий 6 ХЗХ-оос салбар байгуулах, салбарын зөвшөөрөл хүчингүй болгох, оноосон нэр өөрчлөх болон санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн 7 хүсэлт ирүүлснийг хянаж холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангасан 4 ХЗХ-ны хүсэлтийг СЗХ-ны даргын тушаалаар тус тус шийдвэрлэсэн байна.

ХЗХ-ны сонгуульт болон эрх бүхий албаи тушаалтны өөрчлөлт бүртгүүлэх 109, хаягийн өөрчлөлт бүртгүүлэх 7, нийт 116 хүсэлт ирүүлснээс 99 хүсэлтийг хянан шийдвэрлэсэн. ХЗХ-ны нэгдсэн бүртгэлийн санд нэр бүхий 142 ХЗХ-ны дэлгэрэнгүй бүртгэлд оруулсан нийт 261 өөрчлөлтийг тухай бүр шинэчилж бүртгэсэн байна.

#### ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ, ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа болон Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйл ажиллагааны зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн СЗХ-ны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлох эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”, мөн оны 150 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, СЗХ-ны удирдлагуудад танилцуулжээ.

Мөн СЗХ-ны 2021 оны 363 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайн болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд СЗХ-ны 2020 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайн болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан зах зээлд оролцогчид болон олон нийтээс санал авч нэгтгэн журамд шаардлагатай саналуудыг тусгасан байна.

Монгол Улсын хэмжээнд үнэт эдлэлийн борлуулалтын нэгтгэл тайланг гаргах, зайн хяналтыг хялбаршуулах, санхүүгийн амхан шатны баримтаар баталгаажсан тоо мэдээг гаргах, үнэт эдлэлийн борлуулалтын их өгөгдлийн санг бүрдүүлэх ажлын хүрээнд “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ-тай хамтран “Цахим төлбөрийн систем”-ийн аналитик системд хандах ажлыг эхлүүлсэн байна.

Тусгай зөвшөөрлийг 2022 онд Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх 59 хуулийн этгээд, Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх 7 хуулийн этгээд болон 29 иргэнд, 1 хуулийн этгээдийн ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, сэргээх, 1 ҮМҮЧЭТХЭАЭ, 3 ҮХХЗБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай асуудал, нээр бүхий 36 хуулийн этгээдэд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, 4 хуулийн этгээдэд оноосон нэр өөрчлөх, нэр бүхий 2 хуулийн этгээдэд нийт 3 салбар байгуулах зөвшөөрөл олгох тухай асуудлыг СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлсн шийдвэрлүүлжээ.

СЗХ-ны даргын тушаалаар нийт 5 салбар нээн ажиллуулах зөвшөөрлийг нэр бүхий 2 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдэд олгож, 1 хуулийн этгээдийн салбар нээн ажиллуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.


#### СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Сэндбокс зохицуулалтын орчин нь технологид суурилсан шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлагдмал орчинд турших, амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, онцлогт тохирсон зохицуулалтын орчныг бүрдүүлэх чиглэлд зах зээлийн оролцогчид болон бодлого гаргагчид хамтран ажиллах боломжийг олгодог зохицуулалтын арга хэрэгсэл юм. Энэхүү технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих, зах зээлийн өөрчлөлт,

шинэчлэлтэд нийцсэн зохицуулалтын орчныг бүрдүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирал нарын А-63/64/32/A/27 тоот хамтарсан тушаалаар “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдөр баталж, сэндбокс зохицуулалтыг санхүүгийн зах зээлд нэвтрүүлжээ.

Сэндбоксын үйл ажиллагааг 2021 оны 9 дүгээр сард эхлүүлснээс хойш сэндбоксад орох нийт 15 хүсэлт ирсэн ба эдгээр хүсэлтийг бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр нь ангилбал, виртуал хөрөнгийн үйлчилгээ 6, өрийн хэрэгсэл, үзүүт цаас арилжих үйлчилгээ 2, P2P үйлчилгээ, краудфандинг (хамтын санхүүжилт)-ийн үйлчилгээ, репо хэлцлийн үйлчилгээ, валют арилжааны цахим платформын үйл ажиллагаа, технологид сууринсан даатгалын үйлчилгээ, төлбөрийн системийн үйлчилгээ, хэрэглэгчийн таньж мэдэх үйлчилгээ тус тус 1 байна.

#### *Зураг 1. Сэндбокс зохицуулалтын орчинд орох хүсэлт, үйлчилгээний төрлөөр*



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Сэндбоксод туршигдаэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ: 2021-2022 онд “Монпэй” цахим мөнгөнд сууринсан дижитал бонд болон Монимаркет вэб системээр дамжуулан репо хэлцлийн хүсэлт хүлээн авах, хэлцлийн дагуу худалдах, худалдан авах үйлчилгээг Сэндбокс зохицуулалтын орчинд 1 жилийн хугацаатайгаар амжилттай туршжээ:

- Монпэй дижитал бонд нь 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сэндбоксын орчинд туршигдсан бөгөөд 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 12 сарын хугацаатай, жилийн 14 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнс бүхий 10,000 ширхэг Монпэй бондын анхдагч зах зээлийн арилжааг 35 минутын дотор амжилттай зохион байгуулж, 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлсэн. “Сэндбоксын зохицуулалтын орчны журам” болон “Компанийн өрийн

хэрэгслийн бүртгэлийн журам"-ын хүрээнд өрийн хэрэгслээ бүртгэж, анхдагч зах зээлийн арилжааг андеррайтерийн компани зохион байгуулсан нь энэхүү дижитал бондын арилжааны гол онцлог юм. Тус бүтээгдэхүүний сэндбоксын орчинд туршигдах хугацаа нь 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд Сэндбоксын зөвлөлийн 04 дугаар зөвлөмжөөр сэндбокс зохицуулалтын орчноос гаргасан.

- Монимаркет платформоор дамжуулац ББСБ-уудын хоорондох репо хэлцлийн үйлчилгээ нь 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн сэндбоксын орчинд 1 жилийн хугацаанд амжилтай туршигдсан бөгөөд энэхүү үйлчилгээний сэндбоксод туршигдах хугацааг Сэндбоксын зөвлөлийн 05 дугаар зөвлөмжийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргын 550 дугаар тушаалаар ахин 1 жилээр сунгасан. 2022 оны байдлаар уг ББСБ-уудын мөнгөний зах нь нийт 41 оролцогчтой бөгөөд нийт 471 удаагийн хэлцэл хийн 64.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлсэн байна.

2022 оны 4 дүгээр улиралд Сэндбоксын зөвлолийн 06, 07, 08 дугаар зөвлөмжид үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны даргын 551, 552, 553 дугаар тушаалаар дараах 3 бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбокс зохицуулалтын орчинд 1 жилийн хугацаатайгаар шинээр иэмж оруулсан:

- *Технологид суурилсан даатгалын үйлчилгээ*: Энэхүү үйлчилгээ нь хэрэглэгч өөрийн хэрэгцээ шаардлага, эрсдэлд нийцсэн даатгалын бүтээгдэхүүнийг ямар нэгэн зуучлагчгүйгээр өөрөө сонгон хэрэглэх, мөн эрсдэлд суурилсан газрын зураглалыг хөгжүүлж, даатгалын эрсдэлийг үнэлэх зэрэг олон төрлийн давуу талыг хэрэглэгчдэд санал болгож буй.
- *P2P зээлийн үйлчилгээ*: Энэхүү үйлчилгээ нь Монгол Улсын санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч буй үйлчилгээ бөгөөд хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг ашиглан зээлийн онооны үнэлгээ, бүртгэл хийж, хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбож байгаагаараа онцлог давуу талтай.
- *Kraudфандинг буюу хамтын санхүүжилтийн үйлчилгээ*: Зээл, урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь жижиг, дунд, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд төслийн санхүүжилтийн хэрэгцээгээ түргэн шуурхай шийдэх боломжийг олгодог.

Ийнхүү 2022 оны байдлаар, сэндбоксын зохицуулалтын орчинд 4 бүтээгдэхүүн, үйлчилгээ туршигдаж байна. Эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээ нь сэндбоксын орчинд амжилттай туршигдан зах зээлд нэвтэрвэл зээлийн хүү, санхүүжилтийн үйлчилгээний

өртөг буурах, даатгалын хүртээмж нэмэгдэх зэрэг зерэг нөлөө бий болох боломжтой байна.

### **ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангаж хөгжлийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, гадаад хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах үүднээс Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны одрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан байна.

Хууль сурталчлах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооноос Харилцаа холбооны зохицуулах хороо, нэр бүхий өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдээр дамжуулан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хуулиудад заасан шаардлагыг биелүүлэх, бүртгэлгүй этгээд виртуал хөрөнгийн арилжаа эрхлэх, үр шим, ашиг амлах, иргэдийг төөрөгдүүлсэн мэдээ түгээхгүй байх талаар удаа дараа мэдээлэл, мэдэгдэл хүргэж ажиллажээ.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн зохистой орчныг бүрдүүлж, Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага /ФАТФ/, олон улсын стандартад нийцүүлэх, эрсдэлд суурисан аргачлалыг хэрэгжүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарт мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкнаас гаргасан аргачлалын дагуу боловсруулан урьдчилсан хэлэлцүүлгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Монголбанк, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба зэрэг холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөл болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, тэдгээрийн мэргэжлийн холбоод, NFT маркетплэйсүүд зэрэг нийт 80 гаруй этгээдийг оролцуулан зохион байгуулсан байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд мөрдөх 8 журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу СЗХ-ны сайтад байршуулан олон нийтээс санал авч, төрийн болон хувийн хэвшлийн давхардсан тоогоор 290 орчим этгээдийг хамруулсан хэлэлцүүлгийг 11 удаа зохион байгуулж санал авснаар эцэслэн боловсруулж СЗХ-ны ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулжээ. Үүнд:

1. BXYY-ийн бүртгэлийн журам;

2. BXYY-ийн үйл ажиллагааны журам;
3. BXYY-ийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам;
4. BXYY-ийн мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журам;
5. BXYY-ийн үйл ажиллагаа эрхлэх тохиromжтой этгээдийг тодорхойлох;
6. BXYY-ийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох;
7. BXYY-ийн үйл ажиллагаанд зайн болон газар дээрх хяналт шалгалт хийх журам;
8. BXYY-ийн зохицуулалтын үйлчилгээний холс төвлөрүүлэх журам.

СЗХ нь 2022 онд хууль, тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд нэр бүхий 11 этгээдийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдээр бүртгэжээ.

Хууль тогтоомжид заасан шаардлагууд зөрчигдөх, хороонд бүртгэлгүй этгээд шилжилтийн үеийн зохицуулалтыг зөрчинж арилжаа зохион байгуулах, виртуал хөрөнгийг хувьцаа мэтээр нийтэд сурталчилж, хууль бус үйл ажиллагаа үйлдэгдэх эрсдэлт нөхцөл байдлыг илрүүлж нэр бүхий 1 хуулийн этгээдэд мэдэгдэл, 2 хуулийн этгээдэд улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажилласан байна.

#### **МОНГӨ УГДАХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТАЛААР**

Хамтын ажиллагааны зөвлөлөөс байгуулсан хяналт шалгалтын ажлын хэсэг, хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсэг, хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсэг, судалгаа дүн шинжилгээний ажлын хэсэгт СЗХ-ны албан хаагчид ажиллаж МУТСТ тогтолцоог боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчин болон хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах, олон улсын тэргүүн туршлагыг судалж, Монгол Улсад нэвтрүүлэхээр ажиллажсээ.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, инновацийг дэмжсэн, эрсдэлийг бууруулахуйц тогтолцоог бий болгох чиглэлээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг виртуал хөрөнгийн салбарг үндэсний хэмжээнд үнэлэх, журам зааврыг боловсруулж батлуулах, хамтын ажиллагааг өргөжүүлж, иргэд олон нийтийг анхааруулах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

ФАТФ-ын Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулах чиглэлээр АНДМУТБ-т Дахин үнэлгээний тайлан, тодруулгыг тухай бүр хүргүүлж, техник зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр идэвхтэй ажиллаж Санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-ын АНДМУТБ-ээс Малайз Улсын нийслэл Куала Лумпур хотод зохион байгуулсан “25 дахь удаагийн жилийн уулзалт”-д СЗХ-ны төлөөлөл оролцож зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнааснаар Монгол Улсын Зөвлөмж 15-ын үнэлгээг “Хагас хэрэгжсэн” гэж 2021 онд

үнэлснийг “дийлэнх нь хэрэгжсэн” болгож, 1 шатаар амжилттай ахиулсан. Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулснаар Монгол Улс ФАТФ-ын нийт 40 техник зөвлөмжийн 39-ийн үнэлгээ “бүрэн хэрэгжсэн” болон “дийлэнх нь хэрэгжсэн” болж Монгол Улс ФАТФ-ын гишүүн бус орнуудаас зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулсан анхны улс болжээ.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 265 дугаар тогтооолоор “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ыг баталсан бөгөөд “Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2021-2026 оны Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний толовлөгөөг боловсруулах ажлын хэсэгт СЗХ-ны төлөөлөл оролцож, холбогдох саналуудыг хүргүүлэн батлуулсан.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалаар хийх Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба болон хууль сахиулах байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн тусгай ажлын хэсгийг СЗХ ахлан ажиллаж, тус салбарын Үндэсний эрсдэлийн үнэлгээг эцэслэн, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд 2022 оны 6 дугаар сарын 21-нд хүргүүлжээ.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тухай хуульд заасны дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах 8 журмыг боловсруулж батлуулсан бөгөөд тус хуулийн дагуу СЗХ-ид бүртгүүлсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хэрэгжүүлж, блокчэйн агуулж, Chainalysis программыг зайны хяналтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд аудит хийх этгээдийг мэргэшүүлэх асуудлаар Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран онлайн танхим хосолсон эрх олгох сургалтыг зохион байгуулж тус салбарт үүсэж буй бодит кэйс, типологийн талаарх холбогдох цуврал сургалтуудыг орж хамтран ажилласан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, СЗХ-ны зохицуулалттай салбаруудын мэдээлэх үүрэгтэй этгээдийн зайны болон газар дээрх хяналт шалгалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид орсон өөрчлөлтгэй уялдуулан үр дүнтэй, эрсдэлл суурилсан аргачлалаар гүйцэтгэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 339 дүгээр тогтооолоор баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна.

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

Компанийн засаглалыг сайжруулах хүрээнд СЗХ-ны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталжээ.

Шинэчлэгдсэн кодекст бусад орны сайн жишиг болон өөрийн орны онцлогт тохируулан компанийн засаглалын гол субъект болох төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүтэц, үйл ажиллагааны зарчмыг илүү тодорхой, нарийвчлан зохицуулсан. Тухайлбал, ТУЗ нь өөрөө кодексийн хэрэгжилтийг хариуцах, хяналт тавихаар үүрэгжүүлсэн бол нээлгтэй хувьцаат компаниас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд кодексийг үйл ажиллагаандaa мөрдөхийг үүрэг болгосноор хамрах хүрээ нь тэлсэн байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүний чиг үүргийг хэрэгжүүлэх похцөлийг сайжруулах, зөрчлийг мэдээлэх, комплайнсын хяналтын тогтолцоо болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахдаа зайны технологийг нэвтрүүлэхийг үүрэг болгохын зэрэгцээ ТУЗ-ийн дарга, гишүүдийн олонхи нь хараат бус байх, ТУЗ-ийн зүгээс гадаад болон жишиг хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгой анхаарах зөвлөмжүүдийг тусгасан байна.

Мөн компаниудад кодексийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох зорилгоор уг кодексийн хавсралтаар “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн үлгэрчилсэн загвар”-ыг боловсруулан баталсан ба компанийн ТУЗ нь кодексийн хэрэгжилтийг тодорхой хугацаанд арилжаа эрхлэх байгууллагад тайлагнахаас гадна жилийн үйл ажиллагааны тайлан, цахим хуудсаараа дамжуулан иййтэд мэдээлэхийг үүрэг болгожээ.

Тайлант хугацаанд СЗХ нь Монголын хөрөнгийн биржийн 1, 2 дугаар ангилаалд бүртгэлтэй 60 ХК, 34 ХОМК, даатгалын 17 компани, итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй 52 ББСБ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагыг хамруулан шинэчлээ батлагдсан кодексийн танилцуулга, сургалтыг зохион байгуулж, хэлэлцүүлэг хийсэн байна.

### САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Санхүүгийн салбарын нэгдсэн зохицуулалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсын 30 //Даатгал-5, Үзүүлэлт-9, ББСБ-3, ХЗХ-1, Виртуал-1, Нийт салбарт хамаарах-10/ хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд зохицуулалтын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааг бодлогоор хангах, бүртгэл, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, хяналт тавих чиглэлээр 120 орчим журам, дүрэм, заавар, аргачлал, үүнээс 59 хэм хэмжээний акт //Даатгал-13, ҮЦ-19, ББСБ-9, ХЗХ-4, Нийт салбарт хамаарах-4, ҮХХЗҮЭЗ-4, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэлгчийн-6/-ыг СЗХ-оос батлан мөрдүүлж байна.

Эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр СЗХ-ны үйл ажиллагаа, зохицуулалт, хяналтанд хамаарах хуулийн төсөл боловсруулах дараах ажлын хэсэгт СЗХ-ны төлөөлөл

ажиллажээ. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг;
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах ажлын хэсэг;
- Даатгалын багц хуулийн төсөл /Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Даатгалын зуучлалын тухай хуулийн төсөл, Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл/ боловсруулах ажлын хэсэг;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг;
- Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг;
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсэг, хэлэлцүүлэгт бэлтгүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн дэд ажлын хэсэг;
- Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий дэд ажлын хэсэг;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг;
- Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг;
- Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг;
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг;
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг;

- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг.

Мөн Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн пайруулга/-ийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан УИХ-ын 2022 оны 35 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд, зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэх журам болон бусад хэм хэмжээтэй нийцүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарын хууль болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт албан бичгээр хүргүүлсэн бөгөөд тус хуулиудтай холбогдуулан УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх ажлын хэсэгт ажиллаж байна.

Монгол Улсын Захиргааны өронхий хуульд нийцүүлэн нийтээр дагаж мөрдох захиргааны хэм хэмжээний актуудыг шинэчлэн боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх ажлын хүрээнд 2022 онд нийт 12 захиргааны хэм хэмжээний актыг “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сан”-д бүртгүүлсэн байна. Үүнд:

1. СЗХ-ны 2022 оны 275 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам” /ЗХХА-ын улсын нэгдсэн санд 5850 дугаарт бүртгэсэн/;
2. СЗХ-ны 2022 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”/ЗХХА-ын улсын нэгдсэн санд 5851 дугаарт бүртгэсэн/;
3. СЗХ-ны 2022 оны 360 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам”/ЗХХА-ын улсын нэгдсэн санд 5886 дугаарт бүртгэсэн/;
4. СЗХ-ны 2022 оны 520 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчтэй нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журам” /ЗХХА-ын улсын нэгдсэн санд 5980 дугаарт бүртгэсэн/;
5. СЗХ-ны 2022 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам ” /ЗХХА-ын улсын нэгдсэн санд 5807 дугаарт бүртгэсэн/;
6. СЗХ-ны 2022 оны 174 дүгээр тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам” / ЗХХА-ын улсын нэгдсэн санд 5809 дугаарт бүртгэсэн/;

7. СЗХ-ны 2022 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам” /ЗХХА-ын улсын иэгдсэн санд 5810 дугаарт бүртгэсэн/;
8. СЗХ-ны 2022 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”/ ЗХХА-ын улсын иэгдсэн санд 5811 дугаарт бүртгэсэн/;
9. СЗХ-ны 2022 оны 177 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журам” /ЗХХА-ын улсын иэгдсэн санд 5812 дугаарт бүртгэсэн/;
10. СЗХ-ны 2022 оны 305 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам” /ЗХХА-ын улсын иэгдсэн санд 5847 дугаарт бүртгэсэн/;
11. СЗХ-ны 2022 оны 306 дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, түр зогсоох, бүртгэлээс хасах журам” /ЗХХА-ын улсын иэгдсэн санд 5848 дугаарт бүртгэсэн/;
12. СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс” /ЗХХА-ын улсын иэгдсэн санд 5783 дугаарт бүртгэсэн/.

**1.2.2. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЦД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙН ДАГУУ ХИЙСЭН АЖИЛ, ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:**

Санхүүгийн зохицуулах хороо нь 2022 онд зохицуулалтад хамрагдах нийт 3716 зохицуулалттай этгээдийн санхүү, төлбөрийн чадвар болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтэд зайнас болон газар дээрх хяналт, шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.

Хяналт шалгалтыг давхардсан тоогоор нийт 15,480 этгээд буюу 76 хувьд нь санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланд үндэслэн сар, улирал тутам зайны хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд Үнэт цаасны зах зээлийн оролцогч байгууллагууд, Хувьцаагаа олон нийтэд иээлтэй арилжаалсан компаниуд, Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид, Банк бус санхүүгийн байгууллагууд, Хадгаламж, зээлийн хоршоод, Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хийжээ.

Эрсдэлд суурилсан аргачлалыг ашиглан салбар бүрийн зохицуулалттай этгээдүүдэд 2022 онд хийж гүйцэтгэх эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулан, газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд 371 зохицуулалттай этгээдэд газар дээрх хяналт шалгалт хийж, шалгалтын тайлан дүгнэлтээр холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч илэрсэн зөрчил дутагдалд хугацаатай үүрэг даалгавар, УБАШ хүргүүлж биелэлтийг тооцжээ.

Үнэт цаас, даатгал, ББСБ, ХЗХ-ны зохицуулалт хяналтын чиглэлээр 286, Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйл ажиллагааны зохицуулалтын чиглэлээр 60, ББСБ-ын бүртгэл зөвшөөрлийн чиглэлээр 4, компанийн засаглал комплайнсын чиглэлээр 3, нийт 353 УБАШ хүргүүлсэн байна.

Зайны хяналтын хүрээнд давхардсан тоогоор 4552 зохицуулалттай этгээдэд тайлангийн хариу хүргүүлсэн бол 6343 этгээдэд зохистой харьцаа, зохицуулалт үйлчилгээний хөлс, бусад хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар мэдэгдэл, улсын байцаагчийн албан шаардлагыг тус тус хүргүүлэн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллажээ.

2021 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг 2022 оны I дүгээр улиралд 904 байгууллага ирүүлж, 75 хувийн биелэлттэй байна.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн 8 гомдол мэдээллийн дагуу хяналт шалгалтыг хийж I хуулийн этгээд, 7 иргэнд ЗТХ-ийн 11.30 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг үндэслэн 68.0 сая төгрөгийн торгуулийг оногдуулсан бол нэр бүхий 2 YXXZB, 14 YMΥЧТХЭАЭ иргэний үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалтыг хийж 2 YXXZB-д зөрчлийн хэрэг нээж, хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан байна.

Эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагч нараас 2022 оны жилийн эцсийн байдлаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд шийтгэл оногдуулах тухай шийтгэлийн хуудас 44, зөрчилд шийтгэл оногдуулах тухай шийтгэлийн хуудас 15, нийт 59 шийтгэлийн хуудас үйлдэж холбогдогч иргэн, хуулийн этгээдэд нийт 339,000,000.00 төгрөгийн торгууль оногдуулсан байна. Үүнээс хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд шийтгэл оногдуулах тухай шийтгэлийн хуудсаар 194,000,000.00 төгрөгийн торгууль, зөрчилд шийтгэл оногдуулах тухай шийтгэлийн хуудсаар 145,000,000.00 төгрөгийн торгуулийг тус тус оногдуулж Зөрчлийн тухай хууль болон Зөрчин шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллажээ.

Нийт 59 шийтгэлийн хуудаснаас 45 шийтгэлийн хуудсаар оногдуулсан торгууль бүрэн төлөгдсөн, 7 шийтгэлийн хуудсаар оногдуулсан торгууль хэсэгчлэн төлөгдж байна. Мөн 6 шийтгэлийн хуудсаар оногдуулсан торгууль төлөгдөх процесс ажиллагаа явагдаж байгаа

бөгөөд 1 шийтгэлийн хуудсыг холбогдогч эс хүлээн зөвшөөрч шүүхийн байгууллагад нэхэмжлэл гаргасан байна.

Хяналт шалгалт зохицуулалтын чиглэлээр 2022 онд нийт 250 асуудлыг СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн 246 асуудлыг шийдвэрлүүлсэн. Үүнд: үнэт цаасны зах зээлийн хяналтын чиглэлээр 41, даатгалын хяналтын чиглэлээр 2, ББСБ-ын хяналтын чиглэлээр 137, ХЗХ-ны хяналтын чиглэлээр 36, МУТА-ны чиглэлээр 29, бусдаар 1 асуудал хэлэлцүүлэн шийдвэрлүүлжээ.

Төрийн бүх шатны байгууллагуудаас ирүүлсэн санал, мэдээлэл, судалгаа, лавлагаа, хүсэлтийн дагуу зохицуулалттай этгээдүүдийн талаар мэдээ, мэдээллийн хангаж, холбогдох нотлох баримт, санал, дүгнэлтүүдийг хууль журмын хүрээнд хугацаанд нь болон тухай бүр хүргүүлж ажилласан байна.

#### 1.2.3 **ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙН ХАМГАЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХИЙСОН АЖИЛ, ХЭРЭГЛЖҮҮЛСОН АРГАХ СЭМЖКЭС:**

Санхүүгийн хэрэглэгчийн эрх, үүрэг, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг ба хориглох зүйл, санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлага, мэдээллийн ил тод байдал, санхүүгийн үйлчилгээтэй холбоотой гомдол маргааныг шийдвэрлэх, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа, шударга бус зээллэгийн эсрэг арга хэмжээ зэрэг харилцааг зохицуулсан 8 бүлэг бүхий Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж төслийг Азийн хөгжлийн банкны “Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хуулийн зохицуулалтыг хөгжүүлэх төсөл”-ийн олон улсын зөвлөхүүдэд танилцуулан санал авсан байна.

СЗХ нь 2022 онд өмнөх онд шийдвэрлэгдэж дуусаагүй 5 хэрэг, шинээр 13 нэхэмжлэл хүлээн авч, нийт 18 хэрэг, маргаанд нэхэмжлэгч<sup>17</sup>, хариуцагчаар<sup>17</sup> оролцсон. Үүнээс 11 хэрэг нь бүрэн хянан шийдвэрлэгдэж дууссан, 7 хэрэг хянан шийдвэрлэгджээ.

Эрх зүйн ангиллын хүрээнд Захиргааны хэрэг 15 буюу нийт хэргийн 83.4 хувийг эзэлж, Иргэний хэрэг 3 буюу нийт хэргийн 16.6 хувийг эзэлж байна.

Нийт хэргийн 12 буюу 66.6 хувь нь Төрийн хяналт шалгалттай холбоотой бөгөөд 7 буюу 38.9 хувийг Үнэт цаасны, 5 буюу 27.8 хувийг ББСБ-ын, 2 буюу 11.1 хувийг Даатгалын, 2 буюу 11.1 хувийг Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал болон Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн, 1 буюу 5.6 хувийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарууд болон 1 буюу 5.6 хувийг бусад маргаан тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд нийт зөрчлийн шинжктэй 70 гомдол, мэдээлэл бүртгэгдэж, ЭБАТ гомдол мэдээллийг шалган хүлээн авахаас тагталзах саналтай 3, харьяаллын дагуу

шилжүүлсэн 2, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 47, зөрчлийн хэрэг үүсгэсэн 19-ийг шийдвэрлэжээ.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад нийт 276.0 сая төгрөгийн тorgуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн, 185.0 сая төгрөг буюу 67 хувийн төлөлт гүйцэтгэгдсэн байна.

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, иргэн, хуулийн этгээдээс цаасаар болон цахимаар, утсаар, биеэр ирж, 11-11 төвөөр нийт 2,563 өргөдөл, гомдол, хүсэлт ирүүлснээс 773 өргөдөл гомдол, 498 хүсэлтэд хариу, 1064 лавлагаа, 228 тодорхойлолтыг гаргаж хүргүүлсэн, 46 өргөдөл, гомдол хуулийн хугацаандaa хянагдаж байна. Үүнд: /үнэт цаас 186, даатгал 287, ББСБ 154, ХЗХ 39, МУТА – 30, Бусад -77/.

СЗХ-ны албан хэрэг хөтлөлтөд бичгээр ирүүлсэн 580 өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэл, хяналтын карт хөтлөн хяналт тавин ажилласан. Үүнээс: Хяналт шалгалт зохицуулалтын газарт 550 өргөдөл гомдлыг албан бичгээр ирүүлжээ.

Цахимаар буюу Хорооны вэб хуудас, цахим шуудан, 11-11 төвөөр дамжин 157 өргөдөл, гомдол ирснийг хянаж холбогдох хариуг тухай бүр өгч ажилласан. /үнэт цаас 12, даатгал 49, ББСБ 42, ХЗХ 6, бусад 48/. Утсаар болон ажлын байранд ирсэн нийт 500 иргэнд зөвлөгөө, мэдээллийг тогтмол өгч ажилласан байна.

Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйл ажиллагааны зохицуулалтын чиглэлээр тайлант хугацаанд иргээдээс ирүүлсэн 16 өргөдөл, гомдлыг хянаж шийдвэрлэсэн бөгөөд ЗГХЭГ, ХЗБХ, ХЗДХЯ-аас ирүүлсэн өргөдлийг харьяаллын дагуу ЦЕГ-т шилжүүлэн прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Иргэд байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тодорхойлж, лавлагаа, мэдээллийг тухай бүр ЗМС болон холбогдох эх сурвалжаас гаргуулан хүргүүлжээ.

Даатгалтай холбоотой өргөдөл, гомдол гаргасан 51 даатгуулагчийн нөхөн төлбөрг нийт 541.8 сая төгрөгийг олгуулахаар шийдвэрлэж, даатгагч нэр бүхий 24 иргэн, хуулийн этгээдэд нийт 174.4 сая төгрөгийн нөхөн толбор олгогдсон байна.

#### Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх

Олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр 2022 онд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан санхүүгийн мэдлиг дээшлүүлэх хөтөлбөрт “Эрсдэл ба даатгал” сэдвийг оруулсан бөгөөд олон нийтэд санхүүгийн боловсрол олгох, санхүүгийн зах зээлд оролцогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлд хийсэн ажлыг монгол хэлээр 219, англи хэлээр 94 мэдээ бэлтгэн байгууллагын вэб сайтаар дамжуулж олон нийтэд түгээжээ.

Санхүүгийн боловсрол, сургалтын албанаас сургалтын төлөвлөгөөг гарган ээлжит 34 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 2162 оролцогч хамрагдсанаас 1080 оролцогч

шалгалтад тэнцэж гэрчилгээ авсан. Эдгээрээс мэргэшүүлэх, сертификатжуулах сургалтыг 12 удаа зохион байгуулж 255 оролцогч хамрагдсаныас 238 оролцогч болзол шаардлагыг хангаж шалгалтанд тэнцсэн байна.

Сургалт хамтран зохион байгуулагч мэргэжлийн 13 холбоотой гэрээний хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөт сургалтад олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ач холбогдлын талаарх мэдээлэл хийж, зовлөгөөг өгч ажиллажээ.

МУТСТ чиглэлээр нийт зохицуулалттай салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдүүд, төрийн байгууллага, олон нийтийн төлөөлөл нийт 2451 этгээдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр танхимаар болон цахимаар нийт 56 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Мөн Компанийн засаглалын кодекс шинэчлэн батлагдсантай холбогдуулан сургалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан бөгөөд сургалтад нийт итгэлцилийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 54 БСБ-ын гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг оролцуулсан байна.

Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо хамтран “IPO Mongolia 2022 – Хүртээмжтэй хөрөнгийн зах зээл” чуулганы арга хэмжээг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр амжилттай зохион байгуулжээ.

Хөрөнгө оруулагч жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, ХК-ийн ТУЗ-ийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор байгууллагын цахим хуудсаар мэдээлэл хүргүүлжээ.

“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн сар бүрийн дугаарын “Хэрэглэгч” хэсгийн мэдээллийг бэлтгэн нийтэлсэн. Мөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр цахим хуудаст байршуулах иргэдэд мэдлэг олгох зурагт ном, түгээмэл ирдэг асуулт хариултын булан нээн ажиллуулсан байна.

“Зээлдэгч өөрийн санхүүгийн хэрэгцээ, чадамжид нийцсэн зээлээр санхүүжиж байгаа эсэх” судалгааны үр дүнд тулгуурлан “Иргэдийг зээлийн ухаалаг шийдвэр гаргахад нелөөлөх мэдлэг олгох хөтөлбөр”-ийг боловсруулж иргэдэд санхүүгийн мэдлэг, мэдээлэл хүртээх зорилгоор цуврал зурагт хуудсыг сар бүр бэлтгэн “Санхүүгийн хүртээмж” сэтгүүлд нийтэлж, байгууллагын албан ёсны цахим хуудас <http://www.frc.mn/>, Facebook хуудас, ikon.mn дээр тухай бүр нь байршуулж олон нийтийн хүргээл болгожээ.

СЗХ-ны үйл ажиллагаанд хамаарах мэдээллийн холбоосыг [www.sankhuugiiinbolovsrol.mn](http://www.sankhuugiiinbolovsrol.mn) цахим хуудсанд байршуулж, цаашид нэгдсэн сувгаар мэдээлэл түгээх суурь бүтцийг бүрдүүлэн ажиллаж байна.

МУТСТ чиглэлээр иргэдийг санхүүгийн залилан, луйврын схем, санхүүгийн пирамид зэрэг мөнгө угаах суурь гэмт хэрэггүүртэй сэргийлэх, олон нийтийг мэдээ,

мэдээллээр хангах ажлын хүрээнд цахим хуудасны Мөнгө угаахтай тэмцэх цэсийг байнга баяжуулан шинэчилж, үйл явдал, анхааруулга, мэдэгдэлтэй холбоотой хэвлэлийн мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулж ажилласан байна.

### **1.3 ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, бүс шүтгийн санхүүгийн интеграцид нэгдэх үйл явцыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд гадаад орны санхүүгийн зохицуулагч байгууллагууд, олон улсын хамтын нийгэмлэгийн байгууллагууд, мэргэжлийн холбоод болох хөгжлийн допор байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажилласан байна. Үүнд:

#### **1.3.1. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ОРГОЖУУЛЭХ, ОЛООН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР:**

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан бусад албан хаагчдын хамт IOSCO-ын 47 дахь жилийн тайлангийн хуралд оролцсон. IOSCO-ын Ази-Номхон далайн бүсийн дэд хорооны “Хяналт шалгалтын хамтын ажиллагааны олон талт санамж бичиг”-т нэгдэн орсон байна.

*Олон улсын “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)”-тэй хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх чиглэлээр: Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн ажлын хэсгийн уулзалт 2022 оны 5 дугаар сард Эль Сальвадор, Бүгд Найрамдах Эквадор, Коста Рика Улсуудад зохион байгуулагдаж 7 албан хаагч оролцсон.*

Люксембургийн Их Вант Улсад 2022 оны 7 дугаар сард зохион байгуулагдсан “Санхүүгийн хүртээмж ба финтек” бүсийн семинар болон “Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачилга”-ын 9 дүгээр хуралд оролцсон.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн Дэлхийн бодлогын форумд 9 албан хаагч оролцсон. Нийт 20 албан хаагчийг Зүүн европ, төв азийн бүсийн санаачилгын уулзалт, нийгэмлэгийн жилийн тайлангийн хурал, бусад арга хэмжээнүүдэд биечлэн оролцуулж, цахим сургалтад 11 албан хаагчийг хамруулжээ.

*Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)-тай хамтын ажиллагаагаа оргожуулэх чиглэлээр: Үндсэн зургаан бүлэг, 25 дэд арга хэмжээ бүхий “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг боловсруулан батлуулсан. Мөн төслийн тайлан, зөвлөмжийг боловсруулжээ.*

*БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хороо (FSC) болон Санхүүгийн хяналт шалгалтын байгууллагатай (FSS) хамтын ажиллагааг үргэлжлүүлэх чиглэлээр: БНСУ-ын санхүүгийн зохицуулагч байгууллагаас зохион байгуулдаг сургалт, семинаруудад албан хаагчдаа хамруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар мэйл болон албан бичгийг хүргүүлсэн.*

Дэд дарга Т.Цэрэнбадрал FSC-ны орон тооны гишүүн Ким Ен Жэ болон FSS-ын тэргүүн дэд дарга Ли Мюн Сүн нартай 2022 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр уулзалт зохион байгуулсан. Зохицуулагч байгууллагууд МХБ-д бүртгэлтэй компаниудыг Солонгосын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах боломж, эрх зүйн орчныг сайжруулах тухай болон хоёр орны мэргэжилтийн түншлэлийн хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинээр зохицуулалтад ороод буй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, зохицуулалтын чинглэлд туршлага солилицох талаар хамтран ажиллахаар тохиоролцжээ.

*Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбоо (IAIS)-той хамтын ажиллагаагаа оргожуулэх, зохион байгуулжс буй арга хэмжэснэд идэвхтэй оролцож чиглэлээр: Олон улсын даатгалын зохицуулагч байгууллагуудын холбоо (IAIS)-ноос зохион байгуулсан даатгалын компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл, зах зээлийн чиг хандлага, цахим эрсдэл болон гуравдагч этгээдээр дамжуулан үйл ажиллагаагаа /зарим хэсгийг/ явуулахад гарах эрсдэл зэргийг судалж, эдгээр эрсдэлүүдийн даатгалын компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг бууруулах боломжийн талаар судлах зорилгоор байгуулагдсан “Үйл ажиллагааны уян хатан байдлыг хангах ажлын хэсэг (ORTF)”-т ажиллаж байна.*

IAIS-aас Чили улсын Сантиаго хотноо зохион байгуулагдсан Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны 29 дэх удаагийн жилийн тайлангийн хуралд дэд дарга Н.Хүдэрчулуун болон бусад албан хаагчид оролцсон байна.

*Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг /FSA/-тай хамтын ажиллагааг оргожуулжс хүрээнд: Үнэт цаасны чиглэлээр 2 дугаар сарын 21 болон 6 дугаар сарын 01-ний өдрүүдэд 2 үе шаттай цахим сургалт зохион байгуулагджээ.*

*БНЭУ-ын Үнэт цаас, биржийн хороо /Securities Exchange Board of India/ болон Даатгалын зохицуулалт, хөгжлийн газар /Insurance Regulatory and Development Authority/-уудтай хамтын ажиллагааг оргожуулжс чиглэлээр: БНЭУ-ын Үнэт цаас, биржийн хороотой санамж бичиг байгуулсан.*

*Японы Хамтын ажиллагааны агентлаг /JICA/-тай хамтын ажиллагаа оргожуулж чиглэлээр: Төслийг амжилттай хэрэгжүүлж дуусган, эцсийн тайланг хүргүүлсэн ба төслийн дараагийн үе шатыг эхлүүлэхээр JICA-д санал хүргүүлсэн. Төслийн талаар санал солилицох цахим уулзалтуудыг зохион байгуулсан байна.*

### **1.3.2 САНДАМЖ БИЧИГ БАЙГУУЛСЛЫН УЛС ОРЦУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГЛГАА ОРГОЖУУЛСХ ЧИГЛЭЛЭЭР:**

Бүгд Найрамдах Казахстан Улсын Санхүүгийн зах зээлийн хөгжил, зохицуулалтын агентлагтай цахим уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар хоёр орны хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл солицсон.

АНУ-ын ЭСЯ-ны I дүгээр нарийн бичгийн дарга, эдийн засаг худалдааны албаны дарга Жон Чентэй уулзаж крипто валют, блокчейн системийн тослийн санаал хүргүүлэхээр тохиролцжээ.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-ын өргөтгөсөн олон талт санамж бичгийн хүрээнд бусад улсын санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтүүдэд тухай бүр хариу хүргүүлсэн.

Хонг-Конгийн Үнэт цаас, фьючерсийн хороотой байгуулсан хоёр талт санамж бичгийн хүрээнд мэдээлэл авах хүсэлтийг хүргүүлсэн байна.

### **1.3.3. ТӨСӨЛ ХӨТӨЛБОРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСҮҮЧИЙН ХҮСЭЛТИЙГ БАСЫГДАХ**

*Дэлхийн банкнаас хэрэгжүүлэх буй “Тосов санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх тосол”-ийн хүрээнд: Даатгалын багц хууль (Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль), Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Үнэт эдлэл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан.*

Мөн “Компанийн засаглалын кодекс”-ийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулсан байна.

СЗХ-ны албан хаагчдын англи хэлний ярианы болон бичиг /албан/-ийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор англи хэлний дунд хугацааны сургалтыг зохион байгуулсан. Сургалт анхан, дунд, ахисан түвшинд хичээллэж нийт 50 албан хаагч хамрагджээ.

Хадгаламж, зээлийн хоршооны газрын албан хаагчдын чадавхыг сайжруулах зорилгоор “Санхүүгийн дүн шинжилгээ, эрсдэлийн удирдлага-II”- сургалт, “Нягтлан бодох бүртгэлийн актуудыг олон улсын стандартад нийцүүлэх сургалт”-ыг тус тус зохион байгуулсан.

Британийн Даатгалын Итгэмжлэгдсэн Институт (CII)-ын цахим сургалтад Даатгалын газрын 4 албан хаагч хамрагдаж байна.

*Азийн хөгжлийн банк /ADB/-тай хамтын ажиллагааг үргэлжлүүлэх чиглэлээр: “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд олон улсын болон үндэсний зөвлөхүүдэд ХЗХ-ны ЗХЦҮ, зайны үнэлгээний аргачлалын төсөл болон ХЗХ-ны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус тус танилцуулж хэлэлцүүлсэн.*

Төслийн олон улсын болон үндэсний зовлохтэй уулзалт хийж, Ажлын албаны даргын 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/20 дугаар тушаалтын дагуу Орхон, Дархан-Уул аймгуудад үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дыг хамруулан “ХЗХ-ны эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг зохион байгуулжээ.

“Банкны салбарын тогтвортой байдлыг хангах болон үр ашгийг сайжруулах” /Strengthening Banking Sector Stability and Performance/ төслийг 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн. АХБ нь СЗХ, Монгол банк, KPMG-тэй төслийн танилцуулах уулзалт хийсэн бөгөөд СЗХ-оос Output 3-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын саналыг АХБ-нд хүргүүлсэн.

“Төрийн нөөцийн удирдлага, хувийн хэвшлийн хөгжил, санхүүгийн салбарын гүйцэтгэлийг бэхжүүлэх” /Strengthening public resource management, private sector development, and finance sector performance/ төсөл 2022-2025 оны хугацаанд хэрэгжих бөгөөд төслийн баримт бичгийг боловсруулан танилцуулах уулзалтыг зохион байгуулж, Сангийн яамтай санамж бичиг байгуулсан байна.

Финтекийн хууль эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх (Developing Fintech Legal and Regulatory Frameworks for Mongolia) төслийн баримт бичгийг эцэслэх цахим уулзалтыг 2022 оны 8 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулсан. Санамж бичигт АХБ болон СЗХ нь 8 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурж, төслийн баримт бичгийг 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан байна.

*“Ногоон санхүүгисилтийн зах зээлийг хөгжүүлэх” төслийн хүрээнд:* ББСБ-уудын үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм, засаглалын шаардлагуудыг нэвтрүүлэхтэй холбоотой суурь судалгаа хийж, холбогдох бодлого, гарын авлагын төслүүдийг боловсруулсан. Судалгаанд 40 гаруй ББСБ хамрагджээ.

Хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм, засаглалын шаардлагуудыг нэвтрүүлэхтэй холбоотой БОНЗ-ын тайлагналын матриц, гарын авлага, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журамд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулан оролцогч талуудаас санал авсан байна.

*“Нийлүүлэлтийн сүлжээний санхүүгисилтийн зах зээлийг хөгжүүлэх” төслийн хүрээнд:* Авлага худалдан авалт буюу факторингийн үйл ажиллагааны журмын төслийг боловсруулсан.

Авлага худалдан авалтын үйл ажиллагааны цахим семинарыг банк, ББСБ-уудад зохион байгуулсан байна.

#### 1.4 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖИЛ

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн салбарын бодлого, зохицуулалт, хяналтын талаар шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээг үндэслэн тодорхойлж байна.

Зохицуулалтын салбарын мэдээ мэдээллийг тогтмол гаргах олон нийтэд мэдээлэх зорилгоор Санхүүгийн салбарын 2021 оны 4, 2022 оны 1, 2 болон 3 дугаар улирлын тоймд нийтлэх 6 салбарын санхүүгийн тайлангийн тоо, мэдээг нэгтгэн бэлтгэж, хэвлэлийн хурал зохион байгуулан, улирлын тоймыг хэвлүүлсэн ба СЗХ-ны албаи ёсны цахим хуудсанд тухай бүр байршуулж олон нийтийн хүртээл болгожээ.

Олон улсын болон дотоодын санхүүгийн зах зээлийн 7 хоног, сар бүрийн мэдээллийг гаргаж, судалгаа тооцоог хийж хэвшсэн байна. Тухайлбал, сар бүр олон улсын болон Монголын хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, хөдөө аж ахуйн бирж, зээлийн батлан даалтын сангийн холбогдох тоо, мэдээг цуглуван “Санхүүгийн зах зээлийн сарын тойм” /2022.01, 2022.02, 2022.03, 2022.04, 2022.05, 2022.06, 2022.07, 2022.08, 2022.09, 2022.10, 2022.11, 2022.12/-ыг сар бүрийн дараа сарын эхний 7 хоногт багтаан бэлтгэж СЗХ-ны албан ёсны цахим хуудсанд байршуулан олон нийтийн хүртээл болгож ажилласан.

Түүнчлэн 2022 оны байдлаар 52 удаа /Олон улсын үнэт цаасны зах зээл, Монголын үнэт цаас болон хөрөнгийн биржийн арилжааны мэдээ, топ 20, зах зээлийн үнэлгээ зэрэг 7 хоногийн мэдээг нэгтгэн, дараа 7 хоногийн Даваа гариг бүрт “Санхүүгийн зах зээлийн 7 хоногийн мэдээ” нэртэй боловсруулан УИХ-ын ЭЗБХ болон СЗХ-ны удирдлагад цахим хэлбэрээр хүргүүлж мэдээллээр хангаж ажиллажээ.

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнго оруулагчдын итгэлийг сэргээх, зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг дэмжихэд СЗХ-оос гүйцэтгэсэн судалгааны санал, дүгнэлт нь бодлого зохицуулалтын шийдвэр гаргах үндэслэл, харгалзах хүчин зүйлс болж санхүүгийн салбарт зөв бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэж байна. 2022 онд хийсэн судалгаануудыг эмхэтгэн Судалгааны товхимол №3-ыг олон нийтийн хүртээл болгосон байна.

Санхүүгийн зах зээл, хяналт зохицуулалт, эрсдэл, бүтээгдэхүүн үйлчилгээний чиглэлээр 2022 онд дараах судалгаанууд хийгдсэн байна. Үүнд:

1. Үл хөдлөх хөрөнгө, зуучлалын талаар судалсан. Уг судалгаагаар нийт 12 /ОХУ, БНХАУ, АНУ, Их Британи, Япон, Сингапур, Хонк Конг, БНСУ, АНЭУ-ын Дубай хот, Нидерланд, Бразил, Турк/ улсын үл хөдлөх хөрөнгө, зуучлалын салбарын өнөөгийн байдал туршлагыг судлан өөрийн орны үл хөдлөх хөрөнго зуучлалын салбар, түүнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж улмаар хөгжлийн тогтвортой байдлыг хангах, эрх зүйн орчныг сайжруулахад холбогдох боломжигт дүгнэлт саналыг дэвшүүлсэн;

2. Сэндбокс зохицуулалтын журмын олон улсын харьцуулсан судалгаа хийсэн. Энэхүү судалгааны ажлаар 13 /Австрали, Хонг-Конг, Тайланд, Ямайка, Нигер, Кени, Саудын Араб, Зимбабве, Шри-Ланка, Малайз Их Британи, Сингапур, Тайван/ орны сэндбоксын туршлага болон сэндбоксын журам, удирдамжийг судалж Монгол улсын сэндбоксын журамд

тусгагдаагүй олон улсын сэндбоксын журмын заалтуудыг тодорхойлон сэндбокс орчны журмыг сайжруулахад холбогдох санал, дүгнэлтийг боловсруулсан;

3. Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны зарчим, стандарт судалгааг боловсруулсан. Уг судалгаагаар биржийн бус зах зээлд арилжаалагддаг үнэт цаасны шалгуур, оролцогч талууд, дэд бүтэц, зохион байгуулалтын талаар судалж олон улсад явагдаж буй өнөөгийн байдлыг тодорхойлсон;

4. Сүүтэлэд суурилсан хяналт шалгалт ба зохицуулалтыг хэрэгжүүлэх судалгааг гүйцэтгэсэн. Энэхүү судалгаанд СЗХ-ид эрсдэлд суурилсан хяналт шалгалтад технологийг нэвтрүүлэх буюу сүүтэлэйн тогтолцоонд шилжүүлэхэд стратегийг боловсруулах, анхаарах асуудлуудыг судалсан;

5. Даатгалын компанийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга замууд, олон улсын туршлага судалсан. Энэ судалгааны ажлаар Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг даатгалын компаниудын дүрмийн сан болон нөөц сангийн байршлыг дэлгэрэнгүй судалж, даатгалын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, мөн нэр бүхий 3 /БНХАУ, АНУ, Энэтхэг/ улсын даатгалын компаниуд хэрхэн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлдэг, Монгол Улстай эдийн засаг, газар зүйн байршил болон даатгалын зах зээлийн голлох 2 үзүүлэлт болох даатгалын нягтрал, гүнзгийрэлтийн түвшин ойролцоо Бүгд Найрамдах Казахстан Улс, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын туршлагыг танилцуулсан;

6. Даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл, түүний зохицуулалт судалгаанд нэр бүхий 4 /БНХАУ, Швейцар, ХБНГУ, АНУ/ улсын даатгалын эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн арга хэрэгсэл, түүний өнөөгийн байдлыг судалсан;

7. Нээлттэй банкуудад зохицууллагч байгууллагын зүгээс авч хэрэгжүүлж буй баримлах бодлого, туршлага судалгаагаар Монгол Улсын банкны салбарын өнөөгийн байдал, банк олон нийтэд хувьцаагаа санал болгох (IPO)-д хууль, эрх зүйн зохицуулалт, нээлттэй хувьцаат компани болсноор гарах давуу тал, түүнчлэн олон улс дахь банкны салбарын IPO, зохицуулалтын орчны талаар судалсан;

8. Хөрөнгийн зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх олон улсын туршлага судалгаагаар мэргэжлийн хөрөнгө оруулагчдын өнөөгийн байдал, тэдгээрийн үүрэг оролцоо, хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэхийн давуу тал, олон улсын чиг хандлагын талаар судалсан;

9. Хадгаламж, зээлийн хоршооны хувь шийлүүлсэн хөрөнгийн судалгааг өөрийн орны ХЗХ-дын тоон үзүүлэлт дээр судалж санал дүгнэлтийг боловсруулсан ба Дэлхийн хадгаламж, зээлийн хоршооны холбооны загвар хуулийг судалсан;

10. Тогтвортжилтын сан болон хадгаламжийн даатгалын сангийн зохицуулалт хийх ба олон улсын туршлага зээлийн хоршоодын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, тэдэнд хүндрэлтэй асуудал тулгарах үед гарах бизнесийн болон санхүүгийн тогтвортой стандартын тухай судалсан байна.

Бусад судалгаанууд:

- о “Украин Улсад буй дайнаас үүдэн дэлхийн санхүү, эдийн засгийн салбарт үзүүлж буй нөлөөлөл”;
- о Шинэ коронавирус (COVID-19)-ын нөхцөлд зээлийн байгууллагуудад болон салбарт үүсэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулах талаар хэрэгжүүлж буй олон улсын туршлага;
- о Краудфандинг буюу хамтын санхүүжилтийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалт, олон улсын туршлага;
- о Технологид суурилсан үл хөдлөх хөрөнгийг худалдах, худалдан авах, түрээслэх, түрээслүүлэх, хөлслөх, хөлслүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлж буй олон улсын туршлага;
- о Виртуал хөрөнгийн зайны хяналтын систем болох TRM labs, Eliptic, Cipertrace болон Chainanalysis-н туршилтын эрхийг авч туршиж, судалсан;
- о Австрали, Хятад, Япон улсын P2P зээлийн олон улсын өнөөгийн байдал болон зохицуулалтын орчны тухай;
- о Санхүүгийн зах зээл дэх Инновацийн хабын талаар судалгаа;
- о Олон улсын даатгалын зах зээлийн чиг хандлага, тулгамдаж буй асуудлыг тус тус судалжээ.

## 1.5 ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 1.5.1 БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦ

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 47 зорилт, 257 арга хэмжээг гүйцэтгэхээр боловсруулан хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлagnаж, нийт 162 ажилтан, албан хаагчтайгаар ажил үүргээ гүйцэтгэсэн байна.

#### *Хүснэгт 2. СЗХ-ны албан хаагчдын боловсрол, нас, хүйсийн мэдээлэл*

№	Төрийн албан тушаалын ангилал		Боловсрол				Нас/Хүйс			
			Боловсролын зэрэг		Мэргэжил		Нас		Хүйс	
1	Торийн тусгай албан хаагч	3	Доктор	3	Санхүүч, эдийн засаг, иягтайн бодогч	62%	20-25	35	Эрэгтэй	54
2	Торийн захирагааны албан хаагч	150	Магистр	57	Эрх зүйч	15%	25-35	49	Эмчигтэй	108

3	Төрийн үйлчилгээний албан хаагч	9	Бакалавр	100	Бусад мэргэжил	23%	35-45	52		
4			Бүрэн дунд	2			45-60	31		

- ↓ Эмэгтэй-67%, эргэгтэй 33%;
- ↓ 25 дооши-21.2%, 25-35 -29.6%, 35-45 -30.4%, 45 дээши-18.8%;
- ↓ доктор-1.8%, магистр-35.1%, бакалавр-61.7%, бүрэн дунд-1.2%

Албан хаагчдын дундаж наслалт 33 бөгөөд нийт албан хаагчдын 67 хувийг эмэгтэй, 33 хувийг эрэгтэй албан хаагчид эзэлж байна.

СЗХ-ны нэр бүхий 20 албан хаагчид Тэргүүн болон Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг олгуулах саналыг Төрийн албаны зовлөлд хүргүүлсний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 42 дугаар зарлигаар 2 албан хаагчид Тэргүүн түшмэл, Ерөнхий сайдын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 53 дугаар захирамжаар 15 албан хаагчид Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг тус тус олгожээ.

Мөн Төрийн захиргааны албан хаагчийн үр дүнгийн үнэлгээ, төрд ажилласан хугацаа, мэргэшлийн түвшинг харгалzan Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалаар 9 албан хаагчид ахлах болон дэс түшмэлийн зэрэг дэв олгосноор нийт албан хаагчдын 84 буюу 51.8 хувь нь зэрэг дэвтэй байна.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилгоор Төрийн албаны төв байгууллагад тусгай шалгалтын захиалгыг 4 удаа хүргүүлсэн. Дээрх шалгалтад “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”-ын дагуу шатлан дэвшихээр тэргүүн түшмэлийн ангилалд 1, эрхэлсэн түшмэлийн ангилалд 4, ахлах түшмэлийн ангилалд 18, дэс түшмэлийн ангилалд 43, нийт 66 орон тоог зарласнаас 41 албан хаагч төрийн албаанд шинээр томилогдож, тангараг өргөх ажлыг зохион байгуулсан байна.

Улсын ерөнхий байцаагчийн 3 удаагийн тушаалаар Улсын байцаагчийн эрх олгох шалгалтыг зохион байгуулж, 21 албан хаагчид Улсын байцаагчийн эрх олгож, үнэмлэх, тэмдгийг олгожээ.

Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн СЗХ-ны нийт албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн, цахим системд мэдээллийг оруулж, хүний нөөцтэй холбогдолтой дэлгэрэнгүй болон төрөлжсөн нийт 15 төрлийн судалгааг хийж, мэдээллийг тоогтмол шинэчлэн хөтөлж байна.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдлөлийн тайланг тогтоосон хугацаанд нь Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн иэгдсэн системд хүргүүлсэн байна.

### **1.5.2 БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮ, ТӨСВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар СЗХ-ны багцад 7,494.3 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Нийт батлагдсан төсвийн 64 хувийг улсын төсвийн санхүүжилтийн орлого, 36 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зохицуулалтын үйлчилгээний хөлсний орлогоор бүрдүүлэхээс, орлогын гүйцэтгэл 60:40 харьцаатайгаар биелж, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах санхүүгийн нөөцөөр хангаж ажиллажээ.

Нийт орлогын гүйцэтгэл 7,492.8 сая төгрөг бөгөөд нийт зардалд 7,494.3 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 6,309.9 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 16 хувь буюу 1,184.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тайлант хугацаанд нийт үндсэн үйл ажиллагааны орлого 2,709.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 3,102.6 сая төгрөг төвлөрч орлогын гүйцэтгэлийн биелэлт 393.5 сая төгрөгөөр давсан буюу 114.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Нийт орлогыг ангилан харуулбал:*

- ББСБ-ын салбар 1,206.0 сая төгрөг буюу 39 хувь
- Даатгалын салбар 774.0 сая төгрөг буюу 25 хувь
- Үнэт цаасны салбар 814.0 сая төгрөг буюу 26.2 хувь
- Хадгаламж, зээлийн хоршооны салбар 36.5 сая төгрөг буюу 1.2 хувь
- Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн байгууллага 102.9 сая төгрөг буюу 3.3 хувь
- Виртуал хөрөнгө 85.8 сая төгрөг буюу 2.7 хувь
- Бүртгэл зөвшөөрлийн төвлөрүүлсэн 82.5 сая төгрөг буюу 2.6 хувь
- Бусад 0.7 сая төгрөг 0.2 хувь

*Хүснэгт 3. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ*

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл /2022 он/	Өөрчлөлт	Гүйц-т- тээлийн хувь	Нийт гүйцэтгэл ээсчх хувь
			хэмнэлт(-) хэтрэлт (+)		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ДҮН	7,494,357.40	6,309,919.73	(1,184,437.67)	84.1%	100%
1.УРСГАЛ ЗАРДАЛ	7,093,327.30	5,956,168.93	(1,137,158.37)	83.9%	94.3%
1.1.БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,093,327.30	5,956,168.93	(1,137,158.37)	83.9%	94.3%
Цалин холс болон нэмэгдэл суутгал	4,539,314.70	3,943,845.28	(595,469.42)	86.8%	62.5%
Ажил олгогчоос ийнгмийн даатгал тогох шинмийл	607,277.90	607,277.90	0.00	100%	9.6%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,194.10	74,194.10	0.00	100%	1.1%
Хангамж, бараа материалын зардал	32,575.60	32,407.26	(168.34)	99.4%	0.5%
Эд хогшил, ургал засварын зардал	667	667	0.00	100%	0.01%
Томилолт, зочны зардал	571.5	571.5	0.00	100%	0.01%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний толбор, хураамж	1,836,153.60	1,295,186.18	(540,967.42)	70.5%	20.5%
Бараа үйлчилгээний бусад зардал	2,572.90	2,019.70	(553.20)	78.4%	0.03%
1.2.УРГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	286,530.10	250,350.80	(36,179.30)	87.3%	3.9%
Засгийн газрын ургал шилжүүлэг	234,682.8	234,682.8	0.00	100%	3.7%

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалт	15,668.00	15,668.00	0.00	100%	0.2%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	36,179.30	0	(36,179.30)		
<b>2.ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>114,500.00</b>	<b>103,400.00</b>	<b>(11,100.00)</b>	<b>90.3%</b>	<b>1.6%</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг		1,182,941.90			

Нийт зардлын 62.5 хувийг цалин хөлс болон нэмэгдэл суутгал, 20.5 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 9.6 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 3.9 хувийг урсгал шилжүүлэг, 1.6 хувийг хөрөнгийн зардал, 1.9 хувийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөвтэй харьцуулбал цалин хөлс болон нэмэгдэл суутгал 595.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 540.9 сая, урсгал шилжүүлэг 36.1 сая, хөрөнгийн зардал 11.1 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

#### *Хүснэгт 3. Тосвийн гүйцэтгэлийн шинэксилгээг хүснэгтээр харуулбал:*

№	Үзүүлэлт	2021 он		2022 он		Омнох оноос	
		Төловслөгөө	Гүйцэтгэл	Төловслөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,102,786.0</b>	<b>6,081,739.7</b>	<b>7,494,357.4</b>	<b>6,309,919.7</b>	<b>228,180.0</b>	<b>3.7%</b>
1	Бараа ажил үйлчилгээний зардал	6,321,775.2	4,939,093.0	7,093,327.3	5,956,168.9	1,017,075.9	20.5%
2	Урсгал шилжүүлэг	288,492.8	287,144.5	286,530.1	250,350.8	(36,793.7)	-12.8%
3	Хоронгийн зардал	492,500.0	364,084.0	114,500.0	103,400.0	(260,684)	-71.5%

Нийт зардлын дүн өмнөх оноос 228.1 сая төгрөг буюу 3.7 хувиар буурч зарцуулагдсан бөгөөд бараа, ажил үйлчилгээний зардал өсч, урсгал шилжүүлэг болон хөрөнгийн зардал буурсан үзүүлэлттэй байна.

Улсын төсөвт 3,352.7 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 308.1 сая төгрөгийн торгуулийн орлогыг төвлөрүүлж ажилласан байна.

#### **1.5.3 АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ**

СЗХ-ны албан хэрэг хөтлөлт архивын ажлыг “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Баримт бичгийн улсын стандарт”, “Байгууллагын архивын үндсэн заавар”-ын дагуу хөтлөн явуулж байна.

Тухайн хугацаанд 2021 онд хөтлөгдөк дууссан архивын баримтыг зохион байгуулалтын нэгж ажилтнуудаас хуваарийн дагуу хүлээн авч, хадгаламжийн санд 2061 хадгаламжийн нэгжийг байршуулжээ.

Байгууллагын архивын хөмрөгт зайд багтаамж гаргах, архивын баримтыг эргэлтэд оруулах, Санхүүгийн зохицуулах хорооны архивын баримтыг Үндэсний төв архивт шинээр хөмрөг үүсгэж шилжүүлэх зорилготой 2006-2012 оныг хамарсан 6422 архивын баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажил гэрээний дагуу хийгдэж байна.

Архивын баримтаас байгууллага, иргэдийн хүсэлтээр 1535 хуудас, ажилтнуудын албан хэрэгцээнд 562 баримтанд лавлагаа, хуулбар олгожээ.

Тайлант хугацаанд нийт 18,455 албан бичгийн эргэлттэй, үүнээс ирсэн албан бичиг 12 899, гадагш явуулсан албан бичиг 4,976, зохицуулалтын салбарын үйл ажиллагаатай холбоотой иргэд, хуулийн этгээдийн 580 өргөдөл, гомдолд хяналтын картаар хяналт тавин ажиллажээ.

Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээг улирал тус бүрээр нэгтгэн УИХ-ын Тамгын Газарт тухай бүр нь албан бичгээр хүргүүлсэн байна.

#### **1.5.4 МЭДЭЭЛЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ**

СЗХ-ны дотоод үйл ажиллагааг цахимжуулах, цаасны хэрэглээг бууруулах, зарим процессыг автоматжуулах чиглэлээр Microsoft 365 системд дараах системүүдийг гүйцэтгэж, нэвтрүүлсэн байна. Үүнд:

- Мэдээллийн технологийн дуудлагын бүртгэлийн программ;
- Хурлын өрөөний цаг бүртгэлийн программ;
- Хорооны цахим болон танхимиын сургалтын мэдээллийн бүртгэлийн систем;
- Архивын баримт үзэх хүсэлт илгээх программ;
- Олон нийтийн үйл ажиллагааны мэдээллийн бүртгэлийн систем.

“Зөвшөөрлийн цахим систем”-д салбар нэмэх боломжтой болгож хөгжүүлэлтийг хийсэн төдийгүй нэгдсэн цахим системд суурь мэдээллийг нэгтгэж, систем жигд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, эрх бүхий албан тушаалтан, хаяг байршил, агентын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг цахимжуулж, “Цахим албан тоот”-ыг ашиглаж эхэлжээ.

“Төрийн мэдээлэл солилцооны систем”-ээс нэмэлтээр дараах 5-н үйлчилгээг авахаар гэрээг байгуулан ажиллаж байна.

- Их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа тодорхойлолтын мэдээлэл дуудах;
- Тээврийн хэрэгслийн эзэмшигчийн түүхчилсэн мэдээлэл дамжуулах сервис;
- Иргэний мэдээлэл тулгах сервис;
- Үл хөдлөх хөрөнгийн жагсаалт авах сервис;
- Аж ахуйн нэгжийн тайлангийн мэдээлэл авах сервис.

Мөн Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх, бэлэн байдлын зэргийг тогтоож, бэлтгэлийг хангах техникийн тодорхойлолтыг гаргаш, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар нээлттэй мэдээллийг байршуулжээ.

#### **1.5.5. ДОТООД АУДИТ**

### **1.5.5. ДОТООД АУДИТ**

Санхүүгийн зохицуулах хорооны бүтэцэд дотоод аудитын нэгжийг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагад хамааруулан баталсан.

Хууль тогтоомжоор дотоод аудитын үйл ажиллагааг санхүүгийн үйл ажиллагаанд хамааруулан зохицуулсан байдаг боловч тус нэгж нь чиг үүрэг, ажлын цар хүрээг санхүүгийн хяналт шалгалтаар хязгаарлахгүйгээр Олон улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлж байна.

Олон улсын мэргэжлийн практикийн хүрээнд дотоод аудитын үндсэн зорилго, хамрах хүрээг байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаажуулах, зөвлох үйлчилгээ гэж тодорхойлсон байдаг.

Дотоод аудитын зорилго, тодорхойлолт, үндсэн зарчим, стандартад нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооны Стратегii төлөвлөгөө болон Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тооцож, бусад бодлогын баримт бичгүүдэд Хяналт-шириклигээ, үнэлгээ хийжээ.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан удирдамжийн дагуу нэгжүүдийн чиг үүрэг болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, эрсдлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөтэй байдал, зохицуулалттай этгээдүүдийн үйл ажиллагаанд хийгдэж буй хяналт шалгалт нь холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитыг хийж дүгнэлт, зөвлөмж өгч байна.

Дотоод аудитын ажлын хүрээнд аудитын тайлангаар 2022 ид 45 зөрчилд хамаарах 145 зөвлөмжийг хүргүүлснээс 6 буюу 4.1 хувь нь биелэлт тооцох хугацаа болоогүй, 139 буюу 95.8 хувь нь дунджаар 92 хувийн биелэлтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан дотоод аудитын нэгжийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 94 хувьтай бөгөөд байгууллагын дотоод аудитын үйл ажиллагааг Дотоод аудиторын Олон Улсын Институтээс гаргасан тунхаглалууд, Дотоод аудитын мэргэжлийн практикийн үндсэн зарчмууд, ёс зүйн дүрэм, Дотоод аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлж, ажлын баримтуудыг боловсруулан, зөвлөмж хүргүүлсн ажиллаж байна.

## ХОЁР. ӨНООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ХАРЬЦУУЛАЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах санхүүгийн салбар нь 2022 онд ДНБ-ний 23.2 хувьтай тэнцэж байгаа бөгөөд салбар тус бүрээр авч үзвэл Хөрөнгийн зах зээл 14.3 хувь, Даатгалын зах зээл 1 хувь, Банк бус санхүүгийн байгууллага 7.3 хувь, Хадгаламж, зээлийн хоршоо 0.6 хувийг тус тус эзэлж байна.

### САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭСЛДОХ САЛБАРЫН УЗУУДЭЛТҮҮДИЙН ТАЙЛААР ДУРЬДВАЛ:

#### Хөрөнгийн зах зээл:

- Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хүрээнд хөрөнгийн зах зээлд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 595 /Хувьнагат компани-318, Үнэт цаасны компани-52, бусад/ зохицуулалттай этгээд тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна;
- Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 их наяд буюу 15.1 хувиар өссөн, хөрөнгийн зах зээлийн хувь болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 пунктээр буурсан; /Хөрөнгийн зах зээлийн хорвох чадвар бага байгаа нь хөрөнгийн биржид бүртгэлтийн компаниудын хувьцааны товлорол хэт ондор байгаатай холбоотой. 2022 оны эсийн эцсийн байдлаар ТОП-20 индекст багтах компанийудын хувьцааны товлорлийг тооцож үзэхэд хэт товлоролтэй буюу тийт хувьцааны 76.08 хувийг тийт хувьцаа эзэмшигчдийн 0.05 хувь нь эзэмшидэг/;
- Тайлант хугацаанд нийт 594.9 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн бөгөөд үүнээс 343.4 тэрбум төгрөг буюу 57.73<sup>/12.6 хувь оссон/</sup> хувийг хувьцаа, 134.06<sup>/7.8 дахин буурсан/</sup> тэрбум төгрөг буюу 22.54 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 103.75<sup>/24.7 дахин оссон/</sup> тэрбум төгрөг буюу 17.45 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 13.62 тэрбум төгрөг буюу 2.29<sup>/4.1 дахин буурсан/</sup> хувийг хөрөнгө оруулалтын сангийн иэгж эрхийн арилжаа тус тус бүрдүүлсэн;
- Ашигт ажиллагаа сайжирч ҮЦК-ын хөрөнгө 189.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 61.8 тэрбум төгрөг буюу 48.4 хувиар өссөн;
- Топ 20 индекс 37,565.55 нь өмнөх онтой харьцуулахад 6,846.0 иэгжээр буюу 15.4 хувиар буурсан;
- IPO гаргасан 30 компани нийт 348.0 тэрбум төгрөгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 147.8 тэрбум төгрөг буюу 42.4 хувиар өссөн бөгөөд 2022 онд давхардсан тоогоор 14 компани 80.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг иэмэлт хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлжээ;

- Нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаагаар 2022 онд анхдагч зах зээлд 89.9 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оноос 22.5 дахин өссөн;
- Хөдөө аж ахуйн биржээр нийт 1,110.0 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 315.4 тэрбум төгрөгөөр буюу 39.6 хувиар өссөн;
- ХЛАБ-ын нийт хөрөнгө 2022 онд 6.1 тэрбум тогрөгт хүрсэн нь өмнөх оноос 2.8 тэрбум буюу 84.8 хувиар өссөн;
- Биржийн бус зах зээлийн зохицуулалтын орчинд бий болсноос хойшхи хугацаанд хувийн хэвшлээс уг зах зээл дээр компанийн бондыг амжилттай гаргаж эхэлсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрнийн байдлаар нийт 45 үнэт цаас гаргагч компанийн нийт 498.3 тэрбум буюу өмнөх жилээс 213.3 тэрбум төгрөг буюу 74.8 хувийн өссөн дүнгээр санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа биржийн бус зах зээл дээр идэвхтэй арилжаалагдсан байна.

Даатгалын зах зээл:

- Даатгалын зах зээлд 15 ердийн даатгалын компани, 2 урт хугацааны даатгалын компани, 1 давхар даатгалын компани, 63 даатгалын зуучлагч, 25 хохирол үнэлэгч, 40 аудитын компани, 40 актуарч, 137 аудитор, 2376 даатгалын төлөөлөгч, нийт 323 зохицуулалттай этгээд үйл ажиллагаа эрхэлж байна;
- Даатгуулагчдын тоо 133,245-аар иэмэгдэж өмнөх оноос 11 хувиар өссөн;
- 2022 оны байдлаар ердийн, урт хугацааны, давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө 474.9 тэрбум тогрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.5 тэрбум төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн;
- Тайлант хугацаанд 304.8 тэрбум төгрөгийн даатгалын болон давхар даатгалын хураамжийг төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57.3 тэрбум төгрөгөөр буюу 23.1 хувиар өссөн, нийт хураамжийн сүүлийн 3 жилийн дундаж өсөлт 15.4 хувь;
- Даатгалын тохиолдлын улмаас 2022 онд нийт 94.2 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон нь нийт хураамжийн 30.9 хувийг эзэлж байна. Нийт салбарын нөхөн төлбөрийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.3 тэрбум төгрөг буюу 36.7 хувиар өссөн;
- Даатгалын зуучлалын шимтгэлийн орлого 15.2 тэрбум төгрөг, даатгалын хохирол үнэлэгч компани 3.0 тэрбум төгрөгийн даатгалын хохирол үнэлгээний орлоготой ажилласан нь 1.4 тэрбум төгрөг буюу 87.5 хувийн өсөлттэй;

- Тайлант хугацаанд Даатгалын компаниуд 18.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нийт нөөцийн сангийн хэмжээ 216.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 23.2 тэрбум төгрөг буюу 11.9 хувиар өссөн;
- 2022 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниудын хадгаламж, хадгаламжийн сертификат, үнэт цаас, хөрөнгө оруулалт хэлбэрээр хөрөнгийн зах зээлд оруулсан нийт хөрөнгө оруулалт 282.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.5 тэрбум төгрөг буюу 15.3 хувиар өссөн үзүүлэлтгэй байна.

**Банк бус санхүүгийн байгууллагын салбар:**

- Санхүүгийн зах зээлд 2022 оны жилийн эцсийн байдлаар 513 /хороо, орон шугарт 93, гадаадын хөрөнгө оруулалттай<sup>26/</sup> банк бус санхүүгийн байгууллага Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар, харилцагчдын тоо 4.6 сая болж 3.8 хувиар, нийт зээлдэгчдийн тоо 1.2 сая болж 29.2 хувиар тус тус буурсан;
- Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны төрөл өмнөх оны мөн үеэс нэмэгдэж, нийт ББСБ-д эзлэх дүүргээр Зээлийн үйл ажиллагаа 92.9 хувь, Гадаад валютын арилжаа 27.2 хувь, Итгэлцлийн үйлчилгээ 12.4 хувь, Факторингийн үйлчилгээ 8.7 хувь, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх 7.6 хувь, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ 7.2 хувь, Төлбөрийн баталгаа гаргах 5.4 хувь, Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх 4.2 хувь, Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах 0.9 хувь, ҮХЭХБХСЗ 0.1 хувийн тус тус үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг;
- ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 2022 оны жилийн эцсийн байдлаар 3.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.8 тэрбум төгрөгөөр буюу 30.1 хувиар өссөн нь банкны салбарын 7.6 хувьтай тэнцэж байна;
- Активын бүгцийн 72.9 хувь буюу 2.5/<sup>предийн эсэл-88.2%, хуулийн этгээдийн эсэл-11.8%</sup> их наяд төгрөгийг эргэлтийн хөрөнгө болох зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байгаа бол пассивын бүтэцэд 62.1 хувийг эздийн өмч, 37.9 хувийг өр төлбөр тус тус эзэлжээ;
- Хувьцаат капитал өмнөх оны мөн үеэс 161.7 тэрбум төгрөгөөр буюу 14.5 хувиар өсч 1,275.7 тэрбум, хуримтлагдсан ашиг 211.5 тэрбум төгрөгөөр буюу 37.5 хувиар тус тус өссөн;
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 66.4 хувиар буюу 346.5 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 78.2 хувиар буюу 243.6 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 49.0 хувиар буюу 102.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн;
- Нийт орлогод хүүгийн орлого 80.8 хувийг эзэлсэн бөгөөд 2022 онд өмнөх оноос 280.2 тэрбум буюу 66.4 хувиар өссөн;

- Нийт зээл 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.7 их наяд буюу 38.8 хувиар өссөн, ЗЖДХ 3.1 хувьд хүрч 0.4 функтээр өссөн;
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь 7.6 хувьд хүрч 0.6 функтээр өссөн өөрчлөлтүүд гарсан байна.

Хадгаламж, зээлийн хоршооны салбар:

- Хадгаламж, зээлийн хоршоодын тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 196 болж 61 салбар, 762 ажилтан 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 13 буюу 6.2 хувиар буурсан. Үүнээс: Улаанбаатар хотод 107 буюу 54.5 хувь, орон нутагт 89 буюу 45.4 хувь нь үйл ажиллагаа эрхэлж байна;
- ХЗХ-дын гишүүдийн тоо 71,657 хүрч 4.9 хувиар буурсан;
- Нийт хөрөнгийн хэмжээ 267.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23.5 тэрбум буюу 8.0 хувиар буурсан;
- ХЗХ-дын хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн 25.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1.9 хувиар өссөн;
- Нийт хадгаламж 187.5 тэрбум төгрөг болж 16.1 тэрбум буюу 7.9 хувиар буурсан, нийт зээл 210.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.2 тэрбум буюу 1.4 хувиар буурсан, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 3.4 хувь болж 0.1 функтээр буурсан;
- ЗЖДХ 2.3 хувь буюу 0.1 фэнктээр өссөн;
- Цэвэр ашиг 2022 онд 11.6 тэрбум төгрөгт хүрч 0.8 тэрбум төгрөг буюу 7.4 хувиар өссөн;
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь 3.3 хувьд хүрч 0.2 функтээр буурсан;
- Активын бүтцийн 76.6 хувь буюу 205 тэрбум төгрөгийг эргэлтийн хөрөнгө болох зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байгаа бол пассивын бүтгэцд 22.3 хувийг өөрийн хөрөнгө, 77.7 хувийг өр төлбөр тус тус эзэлжээ;
- Нийт зээлдэгчдийн тоо 5,592 буюу 14.7 хувь буурсан, нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 4,940 буюу 14.7 хувиар өссөн;
- Хадгаламжийн жигнэсэн дундаж сарын хүү 1.2 хувь, ЗЖДХ 2.3 хувьд хүрч 0.1 функтээр өссөн;
- ХЗХ-дын хүүгийн орлого 55.9 тэрбум төгрөг буюу 3.1 хувь өссөн, хүүгийн зардал 30.2 тэрбум буюу 5.3 хувь буурсан байна.

Зээлийн батлан даалтын сан

- 2022 онд 13.7 тэрбум төгрөгийн 40 батлан даалтыг гаргасан нь өмнөх онтой харьцуулахад батлан даалтын тоо 6 дахин, дүн 2.5 дахин буурсан үзүүлэлттэй;

- Нийт хөрөнгийн хэмжээ 258.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.5 тэрбум буюу 1.3 хувиар өссөн;
- Нийт орлого 12.2 тэрбум төгрөгт хүрч 15 хувиар, нийт зарлага 3.6 тэрбумд хүрч 38.4 хувиар, цэвэр ашиг 0.6 тэрбум буюу 7.5 хувиар тус тус өссөн;
- Сангийн батлан даалтын үлдэгдэл 2022 онд өмнөх оноос 8.5 хувиар, Батлан даалт гаргасан зээлийн өрийн үлдэгдэл 8.1 хувиар тус тус буурсан байна.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар

- Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны жилийн эцсийн байдлаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 305 хуулийн этгээд байгаа нь өмнөх оны мөн үеэс 57 хуулийн этгээд буюу 22.9 хувиар өссөн. Эдгээр үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагуудын 3 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж нийт 319 брокер, 1,495 агент ажиллаж байна;
- УХЭХЗ-ын компаниудын нийт хөрөнгө 197.1 төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн;
- Нийт орлого 86.0 тэрбум төгрөгт хүрч 2.3 дахин, нийт зарлага 80.1 тэрбум төгрөгт хүрч 2.2 дахин, цэвэр ашиг 5.9 тэрбум төгрөгт хүрч 4 дахин тус тус өссөн;
- Нийт үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагуудын 465 хувьцаа эзэмшигчийн 20.6 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 27 хувиар өссөн;
- 2022 онд 1,971.5 мянган м.кв талбай бүхий 1,705.3 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийг зуучлан худалдсан нь УХХ худалдан борлуулах үйлчилгээ өмнөх оноос 2 дахин өссөн, 7,700 хэлцлийг байгуулан 840.2 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийн 444.1 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлсэн нь зуучлан түрээслүүлэх үйлчилгээ өмнөх оноос 18.8 дахин өссөн байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар:

- 2022 оны жилийн эцсийн байдлаар 47 хуулийн этгээд, 465 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааг эрхэлж байна;
- Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгчдийн 81.4 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 18.6 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг;
- Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй 47 хуулийн этгээд нь 75 хувьцаа эзэмшигчдийн 9.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үеэс 13 хувьцаа эзэмшигчээр буюу 20 хувиар, хувь

нийлүүлсэн хөрөнгө нь 0.9 тэрбум төгрөгөөр буюу 10.5 хувиар өссөн;

- Цэвэр ашиг 14.1 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оноос 5 дахин өссөн;
- 2022 оны жилийн эцсийн байдлаар 8.5 тонн үнэт металлыг 700.1 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 116.5 тэрбумаар өссөн. 8.3 тонн үнэт металлыг 670.8 тэрбум төгрөгөөр борлуулсан нь өмнөх оны мөн үеэс 23.4 тэрбумаар буурсан үзүүлэлттэй байна.

#### Сэндбокс зохицуулалтын орчин

- Тайлант хугацаанд Сэндбоксын орчинд 15 хүсэлтийг ирүүлсэн байна;
- 2022 оны 4 дүгээр улиралд нэр бүхий 3 бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбокс зохицуулалтын орчинд 1 жилийн хугацаатайгаар иэмж оруулан, 1 бүтээгдэхүүнийг гаргаж нийт 4 бүтээгдэхүүн, үйлчилгээг туршиж байна.

#### Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэлгчийн зах зээл

- Нийт 11 компани виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэлгч үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн байна;
- Дотоодын виртуал хөрөнгө 40, гадаад 170;
- BXYY-дийн харилцагчдын тоо давхардсан тоогоор 837,341 бөгөөд эдгээрээс 112,468 нь арилжаанд идэвхитэй оролцогчид;
- Тайлант хугацаанд виртуал хөрөнгийн арилжааны дун 10.0 их наяд төгрөг, зах зээлийн үнэлгээ 326.1 тэрбум төгрөг, одрийн дундаж арилжаа 250.0 сая төгрөг байна. Өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дун шинжилгээ ба харьцуулалтаас харахад санхүүгийн зах зээлийн тоон үзүүлэлтүүд дийлэнх нь осөн иэмэгдсэн буюу эерэг үзүүлэлттэй байлаа.

### **ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээнд байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн судалгаа, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, бусад холбогдох баримт материалыг ашиглан, үнэлгээ хийх арга зүйн дагуу үнэлсэн болно.

Үнэлгээний явцад цуглуулсан нотлох баримт, үнэлгээний дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Санхүүгийн зохицуулах хороо нь 2022 онд “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө 2022-2025”, Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх

үндэсний хөтөлбөрийн 2021-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр 2021-2025, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020-2024 онд хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, Хуулиар тусгайлан олгосон болон нийтлэг олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, Хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, биелэлтийг тайлагнаж ажилласан байна.

Дунд хугацааны буюу 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжүүлснээр зах зээлийн өсөлт хөгжил, тогтвортой байдлыг бодлогоор чиглүүлэн зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг гүйцэтгэсэн байна.

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичиг, салбарын үндэсний хөтөлбөр, байгууллагын стратеги толовложоог үндэслэн 47 зорилт, 257 арга хэмжээг чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэхээр боловсруулжээ. Төлөвлөгөөний арга хэмжээнүүдийн дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилт 95 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” ангилалд хамаарч байна.

Хэрэгжүүлсэн нийт арга хэмжээний 48.2 хувь буюу 124 нь “үр дүнтэй”, 49.8 хувь буюу 128 нь “тодорхой үр дүнд хүрсэн”, 1.1 хувь буюу 3 нь “эрчимжүүлэх шаардлагатай”, 0.7 хувь буюу 2 нь “үр дүнгүй” гэж үнэлэгдсэн бөгөөд төлөвлөлт, түүний хэрэгжилтээс байгууллагын үйл ажиллагаа хэвийн байгааг харуулж байна.

Дундаж үнэлгээгээр “Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх”. “Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2021-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого хөтөлбөр, “Хуулиар нийтлэг олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт”, “Хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилт”, “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт”-ын арга хэмжээнүүд нь 90 хувиас дээш үнэлгээтэй өндөр үр дүнг харуулсан байна.

“Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилт” нь өмнөх оны үнэлгээнээс сайжирсан өөрчлөлтгүй “эрчимжүүлэх шаардлагатай” ангилалд дахин хамрагдсан, Санхүүгийн

хүртээмжийг сайжруулах хотолбөр 2021-2025 зорилтын Олон нийтийн санхүүгийн боловсролын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийх болон Хуулиар нийтлэг олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын Хорооны цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх, бэлэн байдлын зэргийг тогтоож, бэлтгэлийг хангах арга хэмжээнүүд “үр дүнгүй” үнэлгээний ангилалд тус тус хамаарсныг цаашид анхаарч хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан зорилго, зорилтыг хэрэгжүүлснээр зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, хөрөнгийн зах зээл дэх шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдсэн, төлбөр тооцооны бүртгэлийн шинэ систем нэвтэрсэн, иргэдийн санхүүгийн боловсрол, мэдээлэл авах нөхцөл сайжирсан, зохицуулалтын байгууллагын чадавхи, үйл ажиллагаанд таатай нөлөөлөх эрх зүйн орчин бий болсон, үйл ажиллагааны цахим систем, технологийн орчин сайжирсан зэрэг үерэг үр дүнгүүд бий болжээ.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар 2006 онд Хороо үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, хадгаламж зээлийн үйл ажиллагааг хянах зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан бол 2020 онд хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэлтийн үйл ажиллагааг, 2021 онд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулах хянах чиг үүрэг нэмэгдсэний дээр “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ыг боловсруулан СТБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлснээр СЗХ-ны зохицуулалт, хяналтын хамрах хүрээ улам бүр өргөжсөөр байна.

Тус байгууллагаас хэрэгжүүлсэн бодлого, гүйцэтгэсэн ажил, арга хэмжээний үр дүнд 2022 онд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай санхүүгийн салбарын зах зээлийн үнэлгээ болон нийт хөрөнгө нь ДНБ-ний 23.2 хувьд хүрсэн байна.

Санхүүгийн салбарын зах зээлд эзлэх хувь хэмжээ осөн нэмэгдэж, Хөрөнгийн зах зээл, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоо, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын болон үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн нийт 6092 (зохицуулалттай этгээд 3716, даатгалын төлөөлөгч 2376) гаруй санхүүгийн болон зах зээлийн мэргэжлийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэшийн үйл ажиллагааг зохицуулан, хяналт тавьж ажилласан байна.

Нийт зохицуулалттай этгээдийн тоо сүүлийн 5 жилийн байдлаар тогтмол осч, 2018 онтой харьцуулахад 58 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6.9 их наяд төгрөгт хүрч омнөх оны мөн үетэй харьцуулахад 15.1 хувиар өссөнөөр 2022 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) хэмжээтэй харьцуулахад 14 хувьтай тэнцэж байна.

Сүүлийн жилүүдэд Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээ болон банк, санхүүгийн салбарт амжилттай хэрэгжиж буй реформын үр дүнд зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны арилжааны хэмжээ огцом өсч, эдийн засагт гүйцэтгэх үүрэг нэмэгдэж байгааг онцлох нь зүйтэй.

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах, татах идэвх сонирхлыг өсгөх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог өсгөх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх чиглэлд онцгой анхаарч ажилласны үр дүнд зах зээлийн үнэлгээ нэмэгдэн бодит эдийн засагт үзүүлэх нөлөө жилээс жилд өсч байна.

Үнэт цаасны төлбөр тооцооны горимыг олон улсын жишигт нийцүүлэх ажилд онцгойлон анхаарч бодлогын арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлэн төлбор тооцооны T+2, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх шийдвэрийг гаргаснаар системийн хэмжээнд энэхүү горимд амжилттай шилжсэн.

Олон улсын хөрөнгийн зах зээлийн интеграцид нэгдэх, гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг дотоодын биржид давхар бүртгэх чиглэлээр Үнэт цаасны давхар бүртгэлийн журамд хөрөнгө оруулагчид дотоодын болон гадаадын биржүүдийн хооронд үнэт цаасыг чөлөөтэй хөрвүүлэн арилжаалах зохицуулалтыг бий болгож, өмчлөх эрхийн бүртгэлийн холимог тогтолцоог бий болгожсө.

Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдыг дэмжиж, үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамжийг бууруулах чиглэлээр бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд олон улсад хөрөнгийн зах зээлийн индексийг тодорхойлогч Их Британийн FTSE Russell-с гаргадаг Хөгжиж буй зах зээл ангиллын жагсаалтад Монгол Улс ангилал ахих боломж бүрдэж 2022 онд хөгжиж буй зах зээл ангилалд албан ёсоор оржээ.

Энэхүү ангилалд орсноор манай улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татах, зах зээлийн арилжааны идэвх,

хөрвөх чадварыг нэмэгдүүлж, хөгжлийг хурдаасах похцол бүрдэх чухал ач холбогдолтой байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр идэвхтэй ажиллаж, эрсдэлийг тодорхойлох, бууруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, /ФАТФ-/ын зөвломж, стандартыг бислуулэх чиглэлд шат дараалсан арга хэмжээнүүдийг тухай бүр авч хэрэгжүүлэн ажиллаж, Монгол Улсын Зөвлөмж 15-ын үнэлгээг “дийлэнх нь хэрэгжсэн” болгож, I шатаар амжилттай ахиулсан.

Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулснаар Монгол Улс ФАТФ-ын нийт 40 техник зөвлөмжийн 39-ийн үнэлгээ “бүрэн хэрэгжсэн” болон “дийлэнх нь хэрэгжсэн” болж Монгол Улс ФАТФ-ын гишүүн бус орнуудаас зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулсан анхны улс болжээ.

Өмнөх жилүүдэд дотоодын хөрөнгийн зах зээлд зөвхөн хувьцаа, компанийн бонд, ЗГҮЦ гэсэн 3 төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн арилжаалагддаг байсан бол 2020-2022 онд биржээр арилжаалагддаг хамтын хаалттай ХОС, арилжааны зориулаалгатай ХБҮЦ, анхны дижитал компанийн бонд, банкны салбарын реформын хүрээнд гарсан банкны IPO зэрэг цоо шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүний арилжаа амжилттай явагдсан байна.

Банкны тухай хуульд нэмэлт, оөрчлөлт оруулах тухай хуулийг баталснаар банкны системд нөлөө бүхий банкууд IPO хийх замаар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болохоор хуульчилсан нь дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжилд томоохон зерэг өөрчлөлтийг бий болгож байна. Монгол Улсад нийт 5 системийн банк /Хaan банк, ХХБ, Төрийн банк, Хас банк, Голомт банк/ үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүнээс “Төрийн банк” ХХК нээлттэй хувьцаат компани болох ажлыг эхлүүлж, анхдагч зах зээлд хувьцааны арилжааны захиалга нь 100 хувийг давж, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлжээ.

СЗХ-ны 2022 оны 634 дүгээр тогтоолоор “Голомт банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэсэн бөгөөд тус банк нь нийт гаргасан хувьцааныхаа 10.09 хувь буюу 80,402,743 ширхэг хувьцааг нийтэд санал болгож, олон нийтгэс 103.3 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн нь нээлттэй ХК болсон банкны системд нөлөө бүхий хоёр дахь банк болсон байна.

СЗХ-ны 2022 оны 689 дүгээр тогтоолоор “ХААН банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэсэн байна.

Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн өмчтөгийн зохицуулалтад худалдах үндсэн чиглэл”-ийг баталсан.

Энэ хүрээнд Засгийн газраас 2022 оны 6 дугаар сарын 29-ний одрийн хуралдаанаар 2022-2023 онд биржээр төрийн мэдлийн 34 хувийн хувьцааг нээлттэй худалдах, олон нийтийн хяналтад шилжүүлэх төрийн өмчтөгийн хуулийн этгээдийн жагсаалтыг баталжээ.

Төрийн өмчтөгийн компаниудын хувьчлалын үйл ажиллагааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК эхлүүлэн, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 690 дүгээр тогтоолоор бүртгэсэн нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээний нэмж гаргах хувьцааг олон нийтэд санал болгож 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч нийт хөрөнгө оруулагчдаас 57,865,745,500 төгрөгийн үнийн дүн бүхий 7414 захиалга ирсэн нь татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн дүнгээс 4.8 дахин давсан үзүүлэлт болсон байна.

СЗХ-ноос “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталснаар Монгол улсад анх удаа биржийн бус зах зээлд түргэвчилсэн, шуурхай байдлаар компанийн өрийн хэрэгслийг гаргаж, урт хугацааны санхүүжилт татах зохицуулалтын орчин бүрдсэн байна.

Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн хөгжлийн 31 жилийн хугацаанд анх удаа биржийн болон биржийн бус зах зээл зэрэгцэн хөгжих нөхцлийг бүдүүлсэн зэрэг системийн хэмжээнд нөлөөлөх бодлогын чанартай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоогой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангаж хөгжлийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, гадаад хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах үүднээс Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны одрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Хууль сурталчлах, хэрэглэгчдийг мэдээллийэр хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр Харилцаа холбооны зохицуулах хороо, нэр бүхий өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдээр дамжуулан Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хуулиудад заасан шаардлагыг биелүүлэх, бүртгэлгүй этгээд виртуал хөрөнгийн арилжаа эрхлэх, үр шим, ашиг амлах, иргэдийг төөрөгдүүлсэн мэдээ түгээхгүй байх талаар удаа дараа мэдээлэл, мэдэгдэл хүргэж ажиллажээ.

СЗХ нь 2022 онд иэр бүхий 11 этгээдийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч этгээдээр бүртгэж, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд мөрдох 8 журмыг боловсруулан баталсан байна.

УИХ-аас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг 2022 онд баталснаар барьцаалан зээлдүүлэх журмаар олгох болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааны зохицуулалт хяналтын чиг үүргийг СЗХ хариуцан гүйцэтгэхээр болсон байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр баталж Санхүүгийн зохицуулах хорооноос авсан тусгай зөвшөөрөлтэйгээр уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг нээлттэй, ил тод, хараат бус, өрсөлдөөний үндсэн дээр зохион байгуулан, арилжааны гэрээ, хэлцлийг зуучлах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн омчийн оролцоогий хуулийн этгээдэд СЗХ хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхээр хуульчилжээ.

“Төрийн орон нутгийн өмчийн хөрөнгоөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд баталгааны даатгалын холбогдох зохицуулалтыг тусгах чиглэлээр судалгаа, хэлэлцүүлэг хийсэн бөгөөд БНСУ-ын “Сөүлийн баталгааны даатгал” компани, “Үндэсний давхар даатгал” ХК-тай хамтран “Баталгааны даатгал, эдийн засаг дахь үүрэг оролцоо, хэрэгжүүлэх арга хэлбэр” сэдэвт сургалт, уулзалтыг холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын толоөллийг хамруулан зохион байгуулсан байна.

Мөн Олон нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, технологид суурилсан бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, зах зээлийг чадавхижуулах чиглэлд түлхүү анхаарч ажиллажээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ нь зохицуулалтын байгууллагууд, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, байгууллагын стратеги толовлөгөөний зорилтыг хангахад чиглэсэн үр дүнтэй байна.

#### СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

/Н.СОЁЛМАА/

56